

Mongolian Economy

2020 оны 07сар (166)

www.mongolianeconomy.mn

Бодлого

Үндэсний зөвшилцөл

Ковид-19

Гадаад дахь монголчууд




СОРИЛТЫН ЦАГ

ҮНЭ 12,900T



ardshop.mn

онлайн дэлгүүр



- 1 Онлайн худалдааны цогц шийдэл
- 2 Улс орон даяарх анхны мэргэжлийн хүргэлт үйлчилгээ
- 3 Гадаад захиалга хамгийн хямдаар хийх боломж
- 4 24 цагийн харилцагч үйлчилгээний төв
- 5 Захиалга хүргэлтээ хянах технологийн шийдэл
- 6 Төлбөрийн уян хатан шийдэл

Ард Апп

All in ONE



contact@ardshop.mn



цэнэг.эрдэмтэй.өнгөлөх



7575 8001

ГЭРЭЭСЭЭ БҮГДИЙГ АРД АППААР



111th

ANNIVERSARY • SINCE 1910

Samsonite

HOUSE OF SAMSONITE

- Наран Молл 2-р давхарт
/Хүүхдийн 100/
- Наран Плаза 2-р давхарт
/Энхтайваны гүүрний
баруун талд/

TRAVEL WORLD SHOP NARAN

- Наран Плэйс 2-р давхарт
/13-р хорооллын дунд зам/
- Наран Пойнт 1-р давхарт
/Засгийн газрын ордны
баруун хойно/

SAMSONITE BOUTIQUE

- Шангри-Ла Төв 1-р давхарт
/Олимпийн гудамж 19А/

УТАС: 8616-8646



МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЭЭР САР ТУТАМ



МОНГОЛ ШУУДАН
ТҮГЭЭМЭЛ ШУУДАН
-гаар дамжуулан
захиалаарай

Улирлын
захиалга
30.000₮



Утас: 7011-5477, 7011-5476

www.mongolianeconomy.mn

**Mongolian
Economy**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр (9999 4248)

РЕДАКТОР:
Н.Энхбаяр (9916 1303)

"ДЭЛХИЙ" СЭТГҮҮЛИЙН
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
Б.Энхцэцэг (9009 9880)

АНГЛИ РЕДАКТОР:
Жаклин Иветт Йстриж

СЭТГҮҮЛЧИД:
Г.Даваадорж
Г.Орхон
З.Цэлмэг
Б.Мишээл
Т.Сарангуя
(Хятад дахь сурвалжлагч)

ОРЧУУЛАГЧ:
М.Ариунзаяа

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН АЛБА:
Б.Энхцэцэг (9009 9880)
Ц.Оюун-Эрдэнэ (9915 6968)
Г.Амарсайхан (9499 2389)

ХАЯГ: Улаанбаатар,
Чингэлтэй дүүрэг, I хороо,
Экспресс тауэр. 1101 тоот

ВЭБ: www.mongolianeconomy.mn
И-МЭЙЛ:

info@mongolianeconomy.mn

FACEBOOK: Mongolian Economy

TWITTER: EconomyMongolia

УТАС: 7011 5476, 7011 5477

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/х-2762

СЭТГҮҮЛ ЗАХИАЛГА:
Монгол шуудан (Утас: 7007 8916)
Түгээмэл шуудан (Утас: 7011 5015)

Бодлого 6

Үндэсний зөвшилцөл

Олон улс 10

Бэлэн жор

Гадаад дахь монголчууд 12

Цар тахлын үеэр гадаадад өнгөрүүлж буй өдрүүд

Америк 12

Засгийн газрын тодорхойгүй, ойлгомжгүй байдал дарамт, түгшүүр үүсгэж байна

Итали 15

Венец хотын эл хуль гудамж эртний Италийг санагдуулах болсон

Сингапур 18

Хилийн чанадад ажиллаж, хөдөлмөрлөдөг иргэдийнхээ үнэ цэнийг ойлгоосой

Сингапур 18

Хилийн чанадад ажиллаж, хөдөлмөрлөдөг иргэдийнхээ үнэ цэнийг ойлгоосой

Тайланд 21

10 мянган монголчууд минь эх нутагтаа хурдан хариасай гэж залбирч сууна

Франц 24

Эдийн засгийн өсөлтөөс ч чухал зүйл

Швед 27

Швед туршилт буюу сайн дурын дэглэм

Япон 29

Хөл хорио тогтоосноор Токио орхигдсон хот болон хувирсан

Япон дахь монголчууд 30

О.Оюунхүү: Япон дахь монголчуудын хамгийн том асуудал бол мэдээллийн хомсдол

Боловсролын хүртээмж 32

Алдагдсан үеийнхэн

Санхүү 34

Хямралын үед санхүүгээ амжилттай удирдах гурван алхам

Хүний нөөц 36

Хямралын үед хүний нөөцөө хэрхэн удирдах вэ


Үзэл бодол 38

Бүтээлч үйлдвэрлэл – бизнесийн шинэ боломж

Дэлхий 2020 42


Түгшүүрт үе айсуй

Монгол Улсын Эдийн засгийн таамаг



Эх сурвалж: ДБ, АХБ, ОУВС

Цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээ (тэрбум төгрөг)



Эх сурвалж: ОУВС

The Economist 40

Дэлхийн шинэ эмх замбараагүй байдал



Doug Chayka

Ковид-19 ба Монгол Улсын эдийн засаг тавдугаар сар

буурсан	Инфляц
3.3% ↓	
19.0% ↓	Төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ
34.6% ↓	Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл
16.1% ↓	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл
38.5% ↓	Экспорт
13.9% ↓	Импорт
нэмэгдсэн	Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн хэмжээ
29.3% ↑	
39.5% ↑	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл
39.0% ↑	Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн хэмжээ

Эх сурвалж: YCX

Бодлого

Үндэсний зөвшилцөл

Сонгуулийн мөчлөгөөр хэмжигддэг манай улсын нийгэм эдийн засгийн ирэх дөрвөн жилийн амьдрал эхэллээ. Монголчууд нийгмийн тогтолцоогоо өөрчилсөн хагас жарны түүхэнд нэг нам хоёр сонгууль дараалан үнэмлэхүй олонх болж буй анхны тохиолдол нь энэ удаагийнх. Тиймдээ ч эерэг талаас нь харвал бодлогын залгамж халаа, тогтвортой байдал урьд өмнөх жилүүдтэй харьцуулахад нааштай байх болов уу.

Гэвч 10.7 хувиар агшиж сэхээний тасагт очсон эдийн засагтаа эрчимт эмчилгээ хийж, 14.4 тэрбум ам.долларын өртөлж, төсвийн алдагдлаа нөхөж, “хар” ба “саарал” жагсаалтаас гарч, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагалдуулан 30 гаруй хуульд өөрчлөлт оруулах гээд ШИНЭ ПАРЛАМЕНТ, ШИНЭ ЗАСГИЙН ГАЗРЫН

ОУВС-ийн тооцоолсноор энэ онд төсвийн алдагдлыг нөхөхөд 2.5 тэрбум гаруй ам.доллар шаардагдана


тархийг гашилгаж, шандсыг нь хөвчлөх сорилтууд яг л хөхүүрээсээ юу юугүй сагах гэж буй цэгээ шиг хүлээж байна.

Төсөвт тодотгол, алдагдалд санхүүжилт хэрэгтэй

Эдийн засагчид, бизнесийнхний анхааруулж буйгаар сонгуульд зориулсан “ус”-тай төсөв баталсан нь Засгийн газрын өрийг хоёр их наяд орчим төгрөгөөр тэлж, эмзэг эдийн засгийн хүрдийг буруу тийш мушгисан. Энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал дэгдэхээс ч өмнө манай эдийн засаг халуурч, дэмийрэхдээ тулсан байжээ гэсэн үг. Гэтэл чахран ёолж байсан эдийн засагт Ковид-19-ийн хөл хорио эгээ л зогсолтгүй ажиллаж буй араа шүдийг гадас шаагаад хүчээр зогсоож буй мэт тусав. Улмаар төсөв, татвар, экспорт гэсэн гол амин судаснуудын урсгал тасалдаж байгаа нь төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал, гадаад худалдаа зэрэг макро барометрууд уналт заахад хүргэлээ.


Дэлхий нийт Ковид-19 цар тахлыг вакцин гаргаж авахаас нааш зогсоож чадахгүй. Гэвч тэр болтол тэсэх тэнхэл амьсгалын аппарат залгуулсан манай эдийн засагт даанч алга. Оны эхний таван сарын байдлаар төсвийн алдагдал 1.6 их наяд төгрөгт

Монгол Улсын Эдийн засгийн таамаг



Эх сурвалж: ДБ, АХБ, ОУВС

Цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээ (тэрбум төгрөг)



Эх сурвалж: ОУВС

хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого нэг их наяд төгрөгөөр тасалдаж, зарлага 1.1 их наяд төгрөгөөр давав. Мөн экспортын орлого 38 хувь, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 27.3 хувиар агшсан нь цаашид төсвийн орлого тасалдах бодит эрсдэл нүүрлэсэн хэрэг. Төсвийн орлогын тасалдлыг гадаадын зээл тусламж, доноруудын

► санхүүжилтаар нөхөхөөс аргагүй. Ингэснээр өдгөө 2.9 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй Засгийн газрын гадаад өр улам зузаарна.

ОУВС-ийн тооцоолсноор энэ онд төсвийн

Ковид-19 ба Монгол Улсын эдийн засаг

тавдугаар сар

буурсан

3.3% ↓ Инфляц

19.0% ↓ Төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ

34.6% ↓ Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл

16.1% ↓ Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл

38.5% ↓ Экспорт

13.9% ↓ Импорт

нэмэгдсэн

29.3% ↑ Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн хэмжээ

39.5% ↑ Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл

39.0% ↑ Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн хэмжээ

Эх сурвалж: УХХ

Компаниудын борлуулалтын бууралт

(2020 оны I улирал, салбараар)

100% ↓ Урлаг, үзвэр

100% ↓ Боловсрол

100% ↓ Аялал жуулчлал

60% ↓ Баар

47% ↓ Уул уурхай

47% ↓ Тээвэр

42% ↓ Зочид буудал

15% ↓ Бусад боловсруулах

14% ↓ Цайны газар

12% ↓ Жижиглэн худалдаа

10% ↓ Кафе

1% ↓ Хүргэлтийн хоол

0% ↓ Бөөний худалдаа

2% ↑ Ресторан

24% ↑ Хүнс, ундаа

Эх сурвалж: Монголын банкны холбоо

алдагдлыг нөхөхөд 2.5 тэрбум гаруй ам.доллар шаардагдах бөгөөд үүний 1.72 тэрбум ам.доллар нь Хятадын ардын банкинд барагдуулах ёстой своп хэлцлийн дүн юм. Монголбанк болон эдийн засагчдын өгч буй мэдээллээр уг төлбөрийн эргэн төлөлтийг хойшлуулах тул гадаад өрийн дарамт энэ ондоо тэр хэмжээгээр багасна гэсэн үг. Харин

Дэлхийн банк, ОУВС, АХБ-наас нийтдээ 745 сая ам.долларын зээл тусламж авахаар тохиролцож, үлдсэн 46 сая ам.долларыг бусад улс орон, олон улсын санхүүгийн институтээс нөхнө. Энэ нь нийтдээ ДНБ-ий 18.4 хувьтай тэнцэх санхүүжилт бөгөөд тэр хэмжээгээр улсын гадаад өр нэмэгдэнэ.

2016 оноос хойш эрх баригчид Засгийн газрын өрийг ДНБ-ий 20 орчим хувиар бууруулж 69 хувь болгож чадсан ч цар тахлын улмаас сүүлийн хагас жилд ДНБ-ий есөн хувьтай тэнцэх хэмжээний зээл, тусламж доноруудаас аваад байна. Бизнесүүд хүнд байдалд орж, нэгэнт төсвийн орлого тасалдсан тул цаашид халамж тэтгэвэр, цалин хангамжаа өр тавьж олгохоос өөр сонголт шинэ Засгийн газарт байхгүй.

Магадгүй Ковид-19 цар тахал сонгуулийн жилтэй давхцаагүй байсан бол гадаад өрийн асуудал ингэтлээ хоолойд тулахгүй байсан байж магадгүй. Сонгууль угтсан хийрхлийн улмаас энэ оны төсвийг хоёр их наяд гаруй төгрөгийн алдагдалтай баталсан нь эрх баригчдын хамгийн том алдаа гэдгийг чөлөөт эдийн засагч Н.Энхбаяр онцолсон. Хэрэв нэгдүгээр сард хөл хориотой зэрэгцэн төсвөө тодотгосон бол өдийд хоёр их наяд төгрөг орон нутагт байшин барилга биш харин бизнесүүдээ дэмжих, эдийн засгийн цусны эргэлтийг хангах эх үүсвэр болсон байхыг үгүйсгэхгүй. Хамгийн гол нь өрийн дарамт нэмэгдэхгүй байв. ОУВС-ийн шинжээчдийн онцолж буйгаар цар тахлын нөлөө түр хугацааных боловч төсөвт хамгийн том цохилт өгч байгаа. Холболтын гайхамшгийн илрэл болсон даяаршлыг Ковид-19 хумьж буйгаас улс орнуудын худалдаа царцаж, улмаар манай улсын экспортын гол түүхий эдүүд зах зээлгүй болсон нь ийнхүү төсвийг тэжээдэг хамгийн гол эх үүсвэр болох экспортын орлогыг тасалдуулав.

Цаашид хөл хорио хэр удаан үргэлжлэхийг тодорхой хэлэх боломжгүй. Бас гол найдлага болсон нүүрсний экспорт сэргэх эсэх нь өмнөд хөршид дэгдсэн цар тахлын хоёр дахь давалгаа хэр хурдан намжихаас ихээхэн шалтгаална. Тиймээс ШИНЭ ЕРӨНХИЙ САЙД, ДАРААГИЙН ЗАСГИЙН ГАЗАР төсөвтөө тодотгол хийж хөрөнгө оруулалтын зардлаа царцаах, нүүрсний экспортоо эрчимжүүлэх гэсэн хоёр ажлыг нэн яаралтай хийж байж энэ оныг гал алдахгүй үднэ. ►

Ковид-19 дэгдэхээс ч өмнө манай эдийн засаг халуурч, дэмийрэхдээ тулсан байжээ

► Нийт өрхийн 80 хувь хямралд нэрвэгдлээ

Цар тахлын дэгдэлт дэлхий нийтийг хамарч эхлэхэд шинжээчид 71 сая хүн нэн ядуучуудын эгнээнд орно гэж таамаглаж байсан бол Дэлхийн банкны хамгийн сүүлийн тооцоогоор энэ тоо 100 саяд хүрэх нь. Тэгш бус байдлын эсрэг хүчтэй дуу хоолой болсон олон улсын “Oxfam” байгууллага ч нэн ядуучуудын тоо 434 саяар нэмэгдэж, 922 саяд хүрнэ гэсэн таамаг гаргажээ. Ялангуяа энэ эрсдэлд албан бус секторт түлхүү ажилладаг эмэгтэйчүүд, хөдөлмөрлөх эрх нь зөрчигддөг хэсэг илүүтэй өртөмтгий байгаа аж.

Манай улс ч гэсэн энэ дүр зургийн толин тусгал юм. Монголбанк болон МҮХАҮТ-аас хамтран хийсэн “Инфляцын хүлээлтийн судалгаа”-гаар цар тахал орлого багатай хэсэгт хамгийн их нөлөөлжээ. Сарын 500 мянган төгрөг хүртэлх орлоготой өрхүүдийн 83 хувийнх нь амьдрал муудсан бол хоёр сая төгрөгийн орлоготой өрхүүдийн 40 хувьд л нөлөөлсөн гэж хариулжээ. Гэхдээ эдгээрээс төрийн байгууллага болон төрийн өмчит компанийн ажилчдын орлогод цар тахлын нөлөө маш бага байгаа бол хувиараа хөдөлмөр эрхлэгчид, цагийн ажилтнууд хамгийн их өртжээ.

Хэдийгээр Засгийн газраас компаниуд, иргэдийн орлогод дэмжлэг болох зорилгоор орлогын татвар, НДШ-ээс чөлөөлж, торгууль алданги тооцохгүй, ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгож, халамжийн арга хэмжээг өргөтгөж, тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр болсон ч байдал улам дордсоор байна. Үндэсний статистикийн хороо болон Дэлхийн банкнаас гаргасан ядуурлын зураглалаар 2018 онд гурван хүн тутмын нэг нь ядуу ангилалд багтаж буй. Гэтэл цар тахалд хамгийн бага өртөж буй хэсэг болох сарын хоёр сая төгрөгөөс дээш орлоготой өрх нийт өрхийн ердөө л 20 хүрэхгүй хувь нь. Тэгэхээр Монгол Улсын 895 мянга орчим өрхийн 80-аад хувьд цар тахал маш хүчтэй нөлөөлж, ядуурал руу түлхэж байна гэсэн үг.

Хэдийгээр уул уурхай улс орны эдийн засгийг авч явдаг ч ажиллах хүчний бүтцийг аваад үзвэл хүн амын дийлэнх нь худалдаа, үйлчилгээний салбараас амьжиргаагаа залгуулдаг. Гэтэл цар тахлаас сэргийлэх хөл хорио энэ салбарт хамгийн хүнд цохилт өгөв. Улмаар ядуурлын ангил руу унагачихалгүй торгоож байсан хүүхдийн мөнгө, тэтгэвэр тэтгэмжийн гол эх үүсвэр болсон төсвийн данс улайсан нь жилийн хоёрдугаар хагаст монголчууд тэр чигтээ модоо барихыг ёрлолоо. Энэ бол шинэ Засгийн газар илүү чадварлаг, уян хагас, тооцоо судалгаатай, иргэддээ, бизнесүүддээ чиглэсэн бодит алхам хийх хэрэгцээ

шаардлага аминд тулаад ирсний илрэл юм.

Дэлхий дахинд 2009 онд нүүрлэсэн санхүүгийн хямралын улмаас манайд ажилгүйдэл даруй дөрөв дахин нэмэгдсэнийг эдийн засагч С.Даваасүрэн онцолсон. Тухайн үед Оюутолгойн уурхайн хөрөнгө оруулалт, гадаад зах зээл дээр эрчимтэй сэргэсэн түүхий эдийн үнийн ачаар хямралыг хохирол багатай, богино хугацаанд даван туулсан. 2016 оны хямралаар ч гэсэн зэс, нүүрсний үнэ цойлж, Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын ачаар түүртэлгүй даван гарч, эдийн засаг гурван жил дараалан өсөлттэй явж ирсэн. Гэвч энэ удаад байдал өөр. Хэлсэндээ хүрдэг, үндэстнээрээ нэгдэж чаддаг, тэсвэр хатуужилтай зан чанарынхаа ачаар л даван туулахгүй бол урьд өмнө бурхан мэт авардаг байсан гадаад зах зээл царцсан.

Бид хоолойд тулсан өрөө барагдуулахын тулд бас эдийн засгаа аврахын тулд дахиад доноруудаас тусламж дэмжлэг хүсэхээс өөр сонголтгүй. Үүний тулд 2016 оных шиг дахин ОУВС-тай хэлэлцээний ширээний ард сууж, бүсээ чангалах төлөвлөгөөг танилцуулахгүй бол Монгол Улс жинхнээсээ дампуурна. Хаа очиж цар тахалд өртсөн хөгжиж буй орнуудын өрийг нимгэлэх санаачилга дэлхийн бодлого тодорхойлогчид гаргаж байна. Хөгжиж буй орнуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, санхүүгийн найдвартай хэрэгслүүд гаргаж, дампуурахаас сэргийлэхэд зориулж нийтдээ 2.5 их наяд ам.долларын санхүүжилт шаардлагатай гэсэн “Oxfam”-ын судалгаа ч бий.

Ямар ч байсан цар тахлыг даван туулахад зөвхөн нэг улс орон биш харин олон улс хоорондоо илүү сайн ойлголцож, хамтран ажиллаж, хамтдаа даван туулах ёстой гэсэн үзэл санаа түгэж буй.

Тиймээс шинэ Засгийн газарт ч гэсэн иргэд, бизнес эрхлэгчидтэйгээ ойлголцох нь цар тахлын нөлөөг хохирол багатай даван туулах нэг сорилт болох биз. МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин “Төсвөө эргэн харж, тодогтох замаар хямралын үеийн эдийн засагт прагматик хандахгүй бол болохгүй. Сонгуулийн үр дүнд аль нэг нам олонх болсон ч гэлээ хямралыг дангаараа шийдвэрлэх боломжгүй. Үндэсний хэмжээний зөвшилцөлд хүрч байж бодитоор ирсэн хямралыг даван туулах нь тодорхой” хэмээв.

Улс төрийн амбицдаа хөглөгдөж, сонгууль угтсан хийрхэлдээ цэг тавьж, улс үндэстнээрээ нэгдэж илүү эрчимтэй ажиллах цаг ирлээ. Эрх баригчид сонгуульд ялалт байгуулж, улс төрд манлайлсан шигээ одоо элгээрээ хэвтсэн эдийн засгаа өөд татаж, цар тахлыг даван туулах үндэсний зөвшилцөлд манлайлах цаг ирэв. ■

Байр суурь > Бизнесийн төлөөлөл цаг үеийн нөхцөл байдлын талаар байр сууриа илэрхийллээ.

Ш.Нэргүй: 2021 оны тавдугаар сар хүртэл нэг ч жуулчин ирэхгүй болов уу

(“Нью Жуулчин Турс” ХХК-ийн Ерөнхий захирал)

Хорио цээрийн дэглэм тогтоосноос хойш манайх жуулчин хүлээж аваагүй бөгөөд 2021 оны тавдугаар сар хүртэл нэг ч жуулчин ирэхгүй болов уу гэж бодож байна. Учир нь аялал бол ихэвчлэн зургаан сар, нэг жилийн өмнө захиалагддаг бүтээгдэхүүн. Манай компанийн хувьд ажлын байраа хадгалж чадсан аж ахуйн нэгжийн ажилчдад олгож буй 200 мянган төгрөгийг аваагүй. Харьяа Нийгмийн даатгалын газраас асуухад яагаад гэдгийг мэдэхгүй гэх хариулт өгч буй. Үүнээс бусдаар хүсэх зүйл байхгүй.

Хэдий хил хаасны улмаас аялал жуулчлалын салбар сул зогсож байгаа ч энэ нь бидэнд бизнесээ шинэ өнцгөөс харах боломж олгож байна. Тухайлбал, дэлхий дахинд масс аяллын эрч суларч дижитал маркетингт суурилсан цөөн хүний аяллын эрэлт ихсэхийн зэрэгцээ улс орнууд дотоод аялал жуулчлалаа хөгжүүлэхэд анхаарал хандуулж эхэллээ. Манайд дотоодын аялал жуулчлал гэж байдаггүй, ихэнх нь зугаалдаг гэж болно. Зугаалга бол хэн дуртай нь хүссэн газраа явдаг түгээмэл үйлдэл бол аялал илүү танин мэдэхүйн шинж чанартай. Иймд дотоодын аялал жуулчлалыг жинхэнэ утгаар нь бий болгохоор ажиллаж байна. Гэвч энэ чиглэлд тодорхойгүй асуудал олон байгаа учир эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгтэй. Бусад улсын жишгийг харахад дотоодын аялал жуулчлалыг ёс заншлаа танин мэдэх, хүмүүжил олгох тал руу чиглүүлж байна.

Харин төрийн зүгээс мөнгө тараах бус тус салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг нэгтгэж нийт хүлээн авсан жуулчдын тоогоор хөнгөлөлт үзүүлэх зэрэг замаар дэмжвэл зүйтэй. Бид ч гэсэн эвлэлдэн нэгдэх хэрэгтэй. Хувийн хэвшлийнхэн нийлж тооцоо, судалгаагаа гаргаж бодит нөхцөл байдлаа танилцуулах хэрэгтэй. Өмнөх шигээ нэгдсэн ойлголтод хүрэлгүй хөөсөрсөн эл бодлого явуулахгүйн тулд яамны шинэ төлөөлөлтэй нээлттэй ярилцах бодолтой байна.

П.Гялбаа: Холбогдох байгууллагуудтай уулзаж кино театруудыг нээх талаар ярилцаж байна

(“Prime Cineplex” кино театрын захирал)

Манай кино театр энэ жил долоо хоног бүр Холливудын нэг кино мөн жилийн турш 30-40 монгол кино гээд нийт 80-90 орчим кино гаргахаар төлөвлөөд байсан. Гэвч нэгдүгээр сарын 27-ны өдрөөс хорио цээрийн дэглэм тогтож, бид үйл ажиллагаагаа зогсоосон тул эхний хагас жилийн байдлаар нийт орлогынхоо 40 хувийг алдаад байна. Үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор ажилтнуудынхаа

цалинг тавьж чадахгүй байгаа. Уран бүтээлчдийн хувьд киноныхоо нээлтийг онлайнаар эсвэл IPTV-д хийх зэргээр тодорхой арга хэмжээ авч байгаа хэдий ч алдагдлаа нөхөх боломж бага. Учир нь кино театрт хүн бүр нэг тасалбар авч үйлчлүүлдэг бол IPTV-ээс нэг удаагийн худалдан авалтаар нэг өрхийн гишүүд бүгд үзэх боломжтой.

Тавдугаар сард Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар үйл ажиллагаа нь зогссон үзвэр, үйлчилгээний байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж саналыг нь авсан. Салбарын төлөөлөл холбогдох байгууллагуудтай уулзаж кино театруудыг нээх, цаг үеийн нөхцөл байдалд тохирсон үйл ажиллагааны журмын дагуу ажиллах тухай ярилцаж байна. Ингэхдээ кино театруудаа нээж эхэлсэн Япон, Солонгос болон Европын зарим орны туршлагаас санаа авч тусгаж буй.

Б.Оюунтүлхүүр: Засгийн газраас авч буй арга хэмжээ байгаа онохгүй байна

(“Глобал Ложистик” ХХК-ийн Тээвэр хариуцсан ерөнхий менежер)

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 29-ний өдөр УБТЗ ХНН-ээс төлөвлөгөө биелсэн гэх шалтгаанаар тээврийг зогсоосон тул манай компанийн хувьд цар тахлаас өмнө зогсолт хийсэн. Он гараад тээвэрлэлтээ эхлэх байсан боловч хорио цээрийн дэглэмийн улмаас таг зогсож, гуравдугаар сараас хойш ажилтнууддаа цалингийнх нь 50 хувийг л өгч байна. Засгийн газраас авч буй арга хэмжээ байгаа онож чадахгүй байгаагийн нэг жишээ бол манай компани. Орлого нь буурсан ч ажлын байраа хадгалж үлдсэн байгууллагын ажилтнуудад олгох 200 мянган төгрөгийг аваагүйн дээр шаардлагад нийцээгүй гэх шалтгаанаар МҮХАҮТ-аас давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ авч чадаагүй.

Хорио цээрийн дэглэм тогтоосноос хойш зогссон тээврийн салбарт тавдугаар сарын дундаас идэвхжих хандлага ажиглагдаж, одоо л бага багаар хөдөлгөөн орж байна. Гэвч авто тээврийн жолооч нартусгаарлалтад 21 хоног өнгөрөөх шаардлага гарч байгаа нь хүндрэл үүсгэдэг. Үүнээс гадна уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсний төлөө АМНАТ төлөх болсон нь татварын дарамтыг нэмэгдүүлж, хямралд нэрвэгдээд байгаа энэ үед бидэнд ирэх ачааг улам ихэсгэх шалтгаан болж байна.

Манайд тогтсон үнийн стандарт байдаг ч орон нутагт мөрдөгддөггүй, гаднын компаниуд үнэ тогтоож байгаа нь дотоодын компаниудад алдагдалтай байдаг нь бас нэг дарамт болж байгааг дурдах хэрэгтэй болов уу. Тээврийн салбараар дамжин валютын урсгал явагдаж тэр хэмжээгээр эдийн засгийг дэмжиж байдаг тул эдгээр асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. ■

Олон улс

Бэлэн жор

Ковид-19 цар тахлын улмаас дэлхий даяар тодорхойгүй байдал үүсээд буй. Коронавирусийн халдвар авсан хүний тоо нэмэгдсээр аль хэдийнэ есөн саяд хүрлээ. Дэлхийн улс орнууд иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалахын тулд хоорондоо зай барихыг зөвлөж, хөл хорио тогтоож, хилээ хааж, эдийн засгаа “царцаахаас” өөр аргагүйд хүрэв. Үүнээс улбаалж гадаад худалдаа, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогсож, ажилгүйдэл нэмэгдэж, иргэдийн орлого буурч, өрхийн хэрэглээ хумигдав.

Энгийнээр хэлбэл эдийн засгийн хямралыг даван туулахад авч хэрэгжүүлдэг төсөв, мөнгөний бодлого цар тахлын үед хэрэгжих боломжгүй болов. Жишээлбэл, мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн ч цар тахлын тодорхойгүй нөхцөлд иргэд худалдан авалт хийхийн оронд мөнгөө хадгалах гэж оролдох нь тодорхой. Тиймээс корона вирусийн эсрэг үр дүнтэй эмчилгээ, вакцин гарч, халдварын тархалтыг гартаа оруулсан цагт л төсөв, мөнгөний бодлогын механизм хэвийн ажиллаж, эдийн засгаа тэлэх арга хэмжээ авах боломжтой болно. Тэр хүртэл хоорондын зай, хэсэгчилсэн хөл хорио тогтоохын сацуу цар тахлын улмаас хамгийн хүнд хохирол амсаад буй иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг хамгаалах

хэрэгтэй гэж Олон улсын валютын сан зөвлөж байна.

Ковид-19-ийн халдварын голомт болсон Хятад, Орос, АНУ ба Евро бүсийн орнууд ажилгүй, ядуу иргэдийн амьжиргааг хангахад дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. ОХУ-д нэг сарын ажилгүйдлийн тэтгэмжийг 8,000 рублиас цалингийн доод хэмжээ хүртэл буюу 12,130 рубль болгон өсгөж, АНУ-д ажилгүйдлийн тэтгэмжийн санг 268 тэрбум доллароор нэмэгдүүлжээ. Эдийн засаг эргэн сэргэхэд хугацаа орох тул Орос, Хятад, Герман улс ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг нэмж гурван сараар сунгав. Түүнчлэн Германд ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийг шийдвэрлэх хугацааг богиносгосон байна. АНУ-д корона вирусийн халдвар авч ажил эрхлэх

боломжгүй болсон иргэд, хувиараа бизнес эрхлэгчдэд ажилгүйдлийн тэтгэмж авах боломжийг бүрдүүлэв. БНХАУ корона вирусийн халдвар авсан иргэдэд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн бол ОХУ-д бага орлоготой айл өрхөд бэлэн мөнгө, хүүхдийн мөнгө олгох хэлбэрээр дэмжлэг үзүүлж байна. Италид орон нутгийн захиргаагаар дамжуулан ядуу иргэдэд 300 евро, ажилгүй болсон хувиараа бизнес эрхлэгчдэд 600 еврогийн тэтгэмж олгов.

Түүнчлэн дэлхийн хөгжингүй орнууд ажлын байрыг хадгалахын тулд цар тахлын нөлөөгөөр хүнд хохирол амсаад буй аж ахуйн нэгжид буцалтгүй тусламж болон хөнгөлөлттэй зээл олгож байна. Тухайлбал, ОХУ-д хоёр сарын хугацаанд ажилтанд цалин олгоход зориулж жижиг, дунд аж ахуйн нэгжид Засгийн газраас буцалтгүй тусламж олгожээ. Дани улсад Ковид-►



► 19-ийн нөлөөгөөр орлогогүй болсон аж ахуйн нэгжийн ажилтнуудын цалингийн 75 хувийг төр хариуцаж байгаа аж. Германд хуулийн дагуу ажилтныг богиносгосон цагаар ажиллуулахыг зөвшөөрөх болов. Мөн Орос, АНУ-д сарын цалин, цалинтай чөлөө олгоход зориулж жижиг, дунд бизнес эрхлэгчдэд шуурхай зээл олгож буй. Манай урд хөрш энэ жил төгссөн боловсон хүчнээ дэмжих зорилгоор төрийн өмчит компани, төрийн байгууллага, цэргийн албан дахь ажлын орон тоогоо нэмэгдүүлсэн байна.

Харин ААН-ийн орлогыг хамгаалахын тулд Германд жижиг аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчдэд нийт 50 тэрбум еврогийн мөнгөн тусламж олгожээ. Орос, АНУ-д агаарын тээврийн компаниудад тус бүр 23 тэрбум рубль, 25 тэрбум долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдсэн байна. Хятадын Засгийн газар аж ахуйн нэгжийн түрээсийн төлбөрийг, Францын Засгийн газар үйл ажиллагаа нь цалгардсан микро, жижиг, дунд аж ахуйн нэгжийн цахилгаан дулаан, түрээсийн төлбөр, зээлийн хүүг хойшлуулав.

Тэгвэл зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд АНУ, Хятад, Франц жижиг дунд аж ахуйн нэгжид бага хүүтэй зээл олгож, зээлийн шаардлагыг нь сулруулжээ. Хойд хөрш маань хувиараа бизнес эрхлэгчдээ ч орхигдуулсангүй, 2019 онд төлсөн татварыг нь бүтнээр, энэ онд төлсөн татварын зарим хэсгийг буцаан олгож байгаа аж.

Ийнхүү дэлхийн улс орнууд цар тахлын үед юун түрүүнд иргэд, ААН-ийн орлогыг хамгаалахад түлхүү анхаарч буй. Эдгээр нь эдийн засгийн хямралаас гарахын тулд авч хэрэгжүүлдэг богино хугацааны арга хэрэгсэл юм. Гэтэл манай улсад цар тахлын хөл хорионы үед авч хэрэгжүүлж буй багц арга хэмжээ иргэд, аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчдэд хүрч чадахгүй байгаа нь гуравдугаар сарын байдлаар 46 мянган хүн ажилгүй болсноос тод харагдаж байна. Хэдий эрүүл мэндийн салбарт зохистой бодлого хэрэгжүүлж, Ковид-19-ийн тохиолдол дотооддоо бүртгэгдээгүй нь сайшаалтай боловч хилээ хааж, хөл хорио тогтоосон үед иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг хамгаалах арга хэмжээ давхар авахгүй бол ажилгүйдэл 20 хувь, ядуурлын түвшин 50 хувьд хүрэх аюултайг МҮХАҮТ анхааруулсан.



Эдийн засгийн
хямралыг даван
туулахад авч
хэрэгжүүлдэг төсөв,
мөнгөний бодлого цар
тахлын үед хэрэгжих
боломжгүй

Иймд цар тахлын үед хохироод буй иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг хамгаалж, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахын тулд дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж буй сайн туршлагыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна. Үүнд:

- Ажилгүйдлийн тэтгэмжийн болзлыг зөөлрүүлж, хувиараа бизнес эрхлэгчдийг хамруулах, олгох хугацааг нь хөл хорио суллах хүртэл сунгах;
- Коронавирусийн халдвар авсан иргэдэд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж, цалинтай чөлөө олгох;
- Хүүхэд болон ядуу, бага орлоготой өрхүүдэд мөнгөн тусламж олгох;
- Хөл хорионы улмаас үйл ажиллагаа нь цалгардсан аж ахуйн нэгжид буцалтгүй мөнгөн тусламж эсвэл хөнгөлөлттэй зээл олгох,
- Ажилтнуудын цалингийн тодорхой хэсгийг төр хариуцах,
- Шинэ төгсөгчдийг ажлын байраар хангах зэрэг орно

Харин цар тахлын дараа нийгэм, эдийн засгийн байдал тогтворжиж эхлэхээр төсөв, мөнгөний зөөлөн бодлого хэвийн ажиллах боломжтой болно. Харин урт хугацааны эдийн засгийн өсөлтийг бий болгохын тулд эдийн засгаа төрөлжүүлж, иргэдийн боловсрол, шинжлэх ухааны хөгжилд түлхүү анхаарч, технологийн дэвшлийг нэвтрүүлэх нь зөв шийдэл юм. ■

Гадаад дахь монголчууд

Цар тахлын үеэр гадаадад өнгөрүүлж буй өдрүүд

Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн олон улсад хөл хорионд орсон монголчуудын амьдрал, нөхцөл байдал, тэдэнд тулгарч буй бэрхшээл болон оршин суугаа улсынх нь сайн туршлагыг уншигчдадаа танилцуулах зорилгоор "Mongolian Economy" сэтгүүл, вэб сайт "Цар тахлын үеэр гадаадад өнгөрүүлж буй өдрүүд" цувралыг эхлүүлсэн

юм. Сүүлийн сар гаруйн хугацаанд Сингапур, АНУ, Франц, Итали, Швед, Филиппин, Япон улсад ажиллаж, амьдарч буй монголчуудаас ирүүлсэн нийтлэлийг хүргэж байна. Энэ ташрамд ажил, хичээлийн цаг заваа хумслан байж тун сонирхолтой нийтлэл ирүүлсэн та бүхэндээ сэтгүүлийн хамт олон болон уншигчдын зүгээс талархал илэрхийлье.



Улаанбаатар хотод төрсөн. Одоо АНУ-ын Бостон хотод "Эрнст энд Янг" олон улсын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад аудитын менежерээр ажиллаж байна. Япон улсын Хитоцубаши их сургуулийг худалдаа, бизнесийн чиглэлээр төгссөн.



Б.БҮЖИНЛХАМ

Засгийн газрын тодорхойгүй, ойлгомжгүй байдал дарамт, түгшүүр үүсгэж байна

Коронавирусийн нөхцөл байдал Америкт

Коронавирусийн халдварын анхны тохиолдол Америкт энэ оны нэгдүгээр сард бүртгэгдсэн бөгөөд хилийн хоригийг мөн сарын сүүлчээр Хятадаас ирж буй болон дайран өнгөрч буй бүх гадаадын иргэнд тавьж эхэлсэн. Хоёрдугаар сарын сүүлчээр Америкт анхны нас барсан тохиолдол бүртгэгдэж, Засгийн газраас нь иргэдээ гадаад, тэр тусмаа Итали, Өмнөд Солонгос руу зорчихгүй байхыг анхааруулж байв. Энэ үеэр зарим нэг мужид маск зүүсэн Ази хүмүүсийг гадуурхах явдал бага сага гарч байсан болно. Мөн АНУ-ын Халдварт өвчин судлал, хяналтын төвөөс дөрөвдүгээр сарыг хүртэл жирийн амны маск нь корона바이러스ийн эсрэг хамгаалалт болж чадахгүй хэмээж байсан.

Харин гуравдугаар сарын дундуур ДЭМБ-аас онц байдал зарласан бөгөөд энэ үеэс эхлэн АНУ-ын Засгийн газар корона바이러스ийн эсрэг тууштай

арга хэмжээ авч эхэлсэн. Тухайлбал, Европоос (Их Британиас бусад) ирэх хүмүүст 30 өдрийн хилийн хориг тавьж, иргэдийг гэртээ байх, нийтийн тээврээр явахаас зайлсхийх, гэрээсээ ажиллах, гадуур явахдаа хоёр метрийн зай барих, нэг дор 50-иас олон хүн цуглахгүй байхыг уриалсан. Муж бүр харилцан адилгүй хориг тавьж эхэлсэн бөгөөд ихэнх газруудад сургууль, цэцэрлэгийг хааж, хөл хорио тогтоосон. АНУ-ын Халдварт өвчин судлал, хяналтын төвөөс хол хориог зөрчих нь гэмт хэрэг хэмээн зарлаж, зарим мужид шаардлагагүй тохиолдлоор гэрээсээ хол явж буй хүмүүсийг торгож эхэлсэн. Жишээлбэл, Калифорни мужийн Санта Круз хотод мянга хүртэлх долларын торгууль ногдуулж байв. Гуравдугаар сарын сүүлчээр Америкт халдварын 90 мянга шахам тохиолдол, 1000 гаруй нас баралт бүртгэгдсэнээр дэлхийд тэргүүлж эхэлсэн. Хэдийгээр маш олон

► тохиолдол бүртгэгдэж байсан ч тест хийх багаж дутагдалтай байснаас өвчний шинж тэмдэг илэрсэн ч зөвхөн өвчтэй гэж бүртгэгдсэн хүнтэй харилцсан, эсвэл тахал тархсан орноос ирсэн хүмүүсээс л шинжилгээ авч байв.

Хэдийгээр улс даяараа арга хэмжээ авч тахлын эсрэг тэмцэж байгаа ч коронавирусийг санаатайгаар тараах гэсэн хүмүүс ч мэр сэр байх аж. Жишээ нь, дэлгүүрийн лангуун дээрх бараан дээр зориуд ханиалгах, долоох, өвчтэй гэдгээ мэдмэгцээ зориуд олон хөлийн газраар явах гэх мэт үйлдэл гарч байсан ба Хууль зүйн яамнаас үүнийг терроризм гэж үзэн баривчлана гэж сануулснаар намжсан юм. Мөн Мичиган, Миннесота, Охайо зэрэг мужид дөрөвдүгээр сарын дундаас хөл хорионоос болж ажлаа алдсан эсвэл Засгийн газрыг хэтэрхий сүржигнэсэн арга хэмжээ авч байна гэж үзсэн хүмүүс бослого гаргаж эхэлсэн. АНУ-ын ерөнхийлөгч ч үүнийг хөхиүлэн дэмжиж, “Мичиганыг чөлөөл”, “Миннесотаг чөлөөл” хэмээн твиттертээ жиргэснээр хөл хорио тогтоох шийдвэрээсээ эсрэг зүйл хийж байна хэмээн мөн олны шүүмжлэлийг хүртээд байсан билээ. Дөрөвдүгээр сараас эхлэн Нью-Йорк тэргүүтэй зарим мужид шинээр бүртгэгдэх тохиолдол буурч эхэлсэн бөгөөд тавдугаар сараас зарим муж хөл хориогоо сулруулж, эдийн засгаа шат дараатайгаар нээж эхэлсэн.

Ерөнхийдөө Америкт хамгаалах арга хэмжээг хожуу авч эхэлсэн боловч ихэнх газар гуравдугаар сараас маш эрчимтэйгээр хөл хорио тавих, нэн шаардлагатай бус үйлчилгээний газруудыг хаах зэрэг олон арга хэмжээ авсан. Гэсэн ч оношлох багаж төхөөрөмж маш их дутагдалтай байснаас өвчтэй хүмүүсийг оношлох үйл явц удааширч, анх тооцоолж байснаас харьцангуй удаан хугацаанд үр дүн гарч байна.

Миний хувьд нөхөр, охинтойгоо Массачусетс мужийн Бостон хотод ажиллаж, амьдардаг бөгөөд гуравдугаар сарын сүүлээс хөл хорионд орж, цэцэрлэг хаагдсанаар гэрээсээ ажиллах горимд шилжсэн. Массачусетс мужид одоогоор 97,000 тохиолдол бүртгэгдсэн нь АНУ-даа өндөрт тооцогдоно. Ажлын газраас минь уян хатан цагаар ажиллах байдлаар хангаж, гэрээсээ хэрхэн үр дүнтэй ажиллах, өөрийгөө болон гэр бүлээ хэрхэн хамгаалах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх зэргээр олон талаас дэмжиж байгаа.

Коронавирусийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Энэхүү цар тахлаас болж, дэлхийн хамгийн том эдийн засаг урьд байгаагүйгээр уналтанд орж байна. Нийт 30 сая хүн ажилгүй болж, сая сая жижиг, дунд бизнес тэсч үлдэхийн тулд буцалтгүй тусламжийн зээл авахаар хүсэлт гаргаад байгаа билээ. Мөн Америкийн хоёрдугаар улирлын ДНБ 38 хувиар буурна гэж “Морган Стэнли” тооцоолсон байна. Ажилгүйдлийн түвшин дөрөвдүгээр сард



урьд өмнө байгаагүй хэмжээнд буюу 14.7 хувьд хүрсэн нь өмнөх сарын 4.4 хувиас 10.3 хувь өссөн байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгчид гэлтгүй томоохон компаниудад ч хөл хорио маш хүнд тусч байгаа бөгөөд зарим том компани хаалгаа барьж, дампуурлаа зарлахад хүрээд байгаа юм. Жишээлбэл, өнгөрсөн тавдугаар сард J-Crew, Neiman Marcus зэрэг хувцасны брэнд, Америкийн хоёр дахь том машин түрээсийн компани болох Hertz, JCPenny их дэлгүүр дампуурлаа зарласан. Үүнээс гадна томоохон компаниуд ажилчдаа цомхотгохоо зарлаад байгаагаас Chevron, Boeing, IBM, Uber, Airbnb, Virgin Atlantic зэрэг компанийг дурдаж болно.

Зарим шинжээчдийн (UBS Global Wealth Management-ийн хөрөнгө оруулалтын ажилтан Марк Хаефэл) үзэж буйгаар вакцины клиник туршилт амжилттай болж, хөл хориог зогсоож чадвал, Төв банк болоод эдийн засгийн бодлогын хүчээр 2021 ►

► оны эцэс гэхэд эдийн засгийг урьдын хэмжээндээ очно хэмээн тооцоолж байгаа ч хэрэглэгчдийн сэтгэлзүй өөрчлөгдсөнөөр энэ бүхэн илүү удааширна гэж үзсэн хэсэг ч байх аж. Ялангуяа аялал жуулчлал, агаарын тээвэр, зочид буудлын салбар тийм ч хурдан сэргэж чадахгүй болов уу гэсэн хүлээлттэй байна.

Хэдийгээр Америк дэлхийн хамгийн том эдийн засагтай, хамгийн хөгжингүй орны нэг гэгдэж буй ч цар тахал нүүрлэхэд маш олон иргэн нь ажилгүй болон хохирч, эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн үйлчилгээ ч авч чадахгүй байгаа зэрэг нь өнөөдөр бидний эдийн засгийн өндөр дэвшил болоод хөгжлийн тухай ойлголт маань дутагдалтай байгааг харуулж байгаа мэт. Бид өнөөдөр хөгжлийг тооцохдоо эдийн засгийн өсөлт, хувьцааны үнийн өсөлтөнд маш их ач холбогдол өгдөг. Энэ нь ч олон компаниудад байнга үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж байх маш их дарамтыг учруулдаг. Санхүүгийн луйвар хэрэглэсэн компаниуд ихэвчлэн хувьцааны үнээ унахаас сэргийлж, хөрөнгө оруулагчдаасаа өрөө нууж, орлогоо их харагдуулахын тулд луйвар үйлдсэн байдаг. Өсөлтөнд асар их ач холбогдол өгдөг учир цар тахлын үеэр ч маш олон компани ажилчдаа цомхотгож, эргээд энэ нь эдийн засаг, нийгэм болон хувь хүний түвшинд тайван бус байдал үүсгэж байна гэж хэлж болох биз ээ.

Ямартай ч энэхүү цар тахал нь бидний сэтгэлгээнд өөрчлөлт авчирч, эдийн засгийн өсөлт, хөгжлийн тодорхойлолтыг дахин нэг эргэн харах боломжийг олгосон түүхэн үйл явдал болж үлдэх болов уу.


Гадаадад гацсан монголчууд ба Монголын Улсын Засгийн Газар

Америкт сурахаар болон ажиллахаар ирсэн 30 мянга гаруй монголчууд байдаг. Мөн эх орондоо харих хүсэлтээ илэрхийлсэн нийт 11 мянган монгол хүн гадаадад байгаагаас мянга гаруй нь АНУ-д байгаа гэсэн албан бус мэдээлэл бий. Эргэн тойронд минь буй монголчуудаас ажлаа алдсан хүмүүс их байгаа. Мөн Америкт коронавирусийн халдвар авсан 30-аад монгол хүн байгаа гэсэн албан бус тоо бий. Их сургуулиуд кампусаа хааснаар олон оюутан орох газаргүй болж мөн харьж чадахгүйгээс зарим нь визний хугацаагаа хэтрүүлэн харласан байдалтай байна.

Хэдийгээр Монгол Улсын Засгийн газар

иргэдээ хамгаалах үүднээс хилээ хааж, өдий болтол дотооддоо халдварласан тохиолдол гараагүй нь сайшаалтай ч гадаад дахь иргэддээ анхаарлаа хандуулахгүй байгаа нь урдаа байгаа асуудлыг харахгүй гээд нүдээ аниад, чихээ бөглөөд суугаад байгаатай ижил харагдаж байна. Мэдээж манай оронд хангалттай тусгаарлах байр сав, нөөц байхгүйг ойлгож, мөн эмч, сувилагчид болон эрүүл мэндийн ажилтнууд маань ар гэрээ умартан маш сайн ажиллаж иргэдээ хамгаалж байгаад маш их талархаж байгаа.

Гэхдээ Засгийн газрын тодорхойгүй байдал, хэзээ ямар арга хэмжээ авах нь ойлгомжгүй байгаа нь хамгийн их дарамт, түгшүүр үүсгээд байгаа мэт харагдаж байна.



Учир нь Монголоос бусад улсад бүх зүйлийг эртнээс төлөвлөж бэлддэг. Тиймээс хэзээ хүртэл гадаадад гацахаа, хэзээ онгоцонд багтаж харих боломжтой зэргээ мэдчихвэл энэ нь өөрөө маш их тус болж, гацсан иргэд маань ч хаана, яаж байхаа төлөвлөх боломжтой болох юм. Саяхан Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн вакцин гаргал хилээ нээхгүй гэж мэдэгдсэн нь энэ тодорхойгүй байдлыг улам дэвэргэх шиг болсон. Тиймээс тодорхой судалгаа хийгээд, түүнийгээ ард олонтойгоо хуваалцаж, шат дараалалтай төлөвлөгөө боловсруулна уу гэж төр засгийн удирдлагуудаасаа хүсмээр байна.

Мөн зарим хүн гадаадаас ирэхийг хүсэж буй монголчуудаа гадуурхах үзэл гаргаж буй нь маш харамсалтай. Харьж чадахгүй гацсан хүмүүсийн нөхцөл байдал янз бүр байгаа. Тэдэн дунд эмчилгээнд орсон хүмүүс, тэмцээн уралдаанд улсынхаа нэрийг гаргахаар явсан хүүхдүүд, хөгшин, бага насны хүүхэдтэй иргэд байгаа гэдгийг, мөн эдгээр хүмүүс маань өвчин авчирч та бүхэнд халдаах гээд байгаа биш гэдгийг ойлгоосой гэж хүсэж байна. ■



Ромын урлагийн их сургуулийг кино найруулагчаар төгссөн. Одоогоор Венец хот дахь Opera ресторанд ажиллаж байна.



Б.АСБЯЯР

Венец хотын эл хуль гудамж эртний Италийг санагдуулах болсон

Дэлхийг тойрч үзэх мөрөөдөлдөө хөтлөгдөн 2019 оны зунаас би Европоор унадаг дугуйгаар аялж эхэлсэн юм. Удалгүй аяллаа түр зогсоож Венец хотод түр суурьшин хотын захад байрлах нэгэн жижиг ресторанд зөөгчөөр ажилд орж билээ. Нэг л мэдэхэд аялал жуулчлалын хөл хөдөлгөөн өрнөсөн Венец хотын амьдралд ээнэгшин дассан байлаа.

Шинэ он гараад удаагүй байтал БНХАУ-д гарсан шинэ төрлийн коронавирусийн тухай мэдээлэл телевиз, радио, нийгмийн сүлжээгээр цацагдаж байсан нь саяхан мэт. Хоёрдугаар сарын эхээр Ром хотод ирсэн Хятадын хоёр жуулчнаас коронавирусийн халдвар илэрч Итали улс дахь анхны тохиолдол болон бүртгэгдсэн юм. Үүнээс долоо хоногийн дараа Ухань хотоос ирсэн итали иргэнээс Ковид-19-ийн халдвар илэрч нийт халдвар авсан хүний тоо гурав болов.

Тухайн үед италичууд санаа зовсон байдалтай харагдавч коронавирусийн тухай мэдээг ноцтойгоор хүлээж авахгүй байлаа. Жишээлбэл, манай рестораны ажилтнууд Ковид-19-ийг хор хөнөөл, аюул мэтээр авч үзэлгүй тоглоом шоглоом болгон ярьж байсан даг. Харин хоёрдугаар сарын дунд үед Ломбарди мужид коронавирусийн 25 шинэ тохиолдол бүртгэгдэж, хоёрдугаар сарын сүүлч гэхэд уг тоо 60 болж, цар тахлын улмаас 22 хүн нас барав. Гуравдугаар сарын эхэн гэхэд Итали улс Ковид-19-ийн халдварын голомт болон хувирлаа.

Италичууд цар тахалтай хэрхэн тэмцэв

Цар тахлын голомт болсон Ломбарди муж болон ойр орчимд нь гуравдугаар сарын 8-нд хөл хорио тогтоож, дараагийн өдөр нь Итали



улс даяар хөл хорио тогтоох шийдвэр гаргасан. Түүнчлэн гуравдугаар сарын 11-нд шинэ төрлийн коронавирусийн халдварын тархалтыг зогсоох зорилгоор ажилдаа явах, эрүүл мэндийн үйлчилгээ авах болон эмийн сан, хүнсний дэлгүүрээр үйлчлүүлэх зэргээс бусад хөдөлгөөнийг бүрэн хязгаарласан юм. Миний ажилладаг ресторан мөн адил хаалгаа барьсан бөгөөд ердөө нэг сар үргэлжлэх болов уу гэж найдаж байсан хөл хорио хоёр сар үргэлжлэв.

Италид амьдарч буй хүмүүс хоёр сарын турш хөл хорионд орж, тусгай зөвшөөрлийн бичиггүй гадуур явсан тохиолдолд 3000 евро хүртэлх торгууль төлөх зохицуулалт Засгийн газраас гаргасан. Тиймээс би зөвхөн хүнсээ цуглуулах зорилгоор гэр, супермаркетын хооронд л явдаг ►

- болов. Хүнсний дэлгүүрийн гадаа маск зүүсэн хүмүүс хоорондоо дор хаяж нэг метрийн зайтай дугаарлаж, нэг нэгээрээ дотогш ордог байлаа. Хятад эсвэл АНУ шиг бусдад санаатайгаар коронавирус тараах гэсэн оролдлого италичуудын дунд гарсангүй.



Хөл хорионд байхад коронавирусийн халдвар авсан хүний тоо эрчимтэй нэмэгдэж байна, халдвар авсан хүний тоогоор Итали дэлхийд дээгүүрт орлоо, эмнэлгийн хүчин чадал хүрэлцэхээ байлаа гэх мэдээ тасрахгүй байв. Тэр ч бүү хэл Италид маскны хомсдол үүсэж, эмч нар маскгүй ажиллаж байна гэсэн мэдээ хүртэл дуулдсан. Ковид-19-ийн эсрэг хамтдаа тэмцэхийн тулд Хятад, Бразил, Австри, Албани улсууд Италид тусламжийн гараа сунган маск нийлүүлж, эмч нараа хүртэл илгээж байсан нь сайшаалтай.

Цар тахлын улмаас гэрийн хорионд буй италичууд бие биедээ урам өгөхийн тулд тагтан дээрээ чанга дуугаар хашгирна, дуу дуулна, бүр “диско”-дох залуучууд ч байв. Энэ нь Италид амьдарч буй хүмүүст итгэл найдвар төрүүлж, надад ганцаараа биш гэдгийг минь сануулсан юм даа.

Энэхүү үйл явдлаас Италийн ард түмэн ямар өөдрөг, найрсаг, дулаахан хүмүүс вэ гэдгийг харж болох биз ээ.

Итали дахь монголчууд

Анх Итали улсад Ковид-19-ийн халдвар илрэхэд монгол иргэд сандарч, нутаг буцдаг бил үү гэж ярьцгааж билээ. Тэр дундаа ажил, аяллын зорилгоор түр хугацаагаар ирсэн монголчууд хамгийн хүнд байдалд байсан юм. Эдгээр хүмүүс

хоноглох газаргүй, хэтэвчиндээ мөнгөгүй шахуу, хоол хүнсээ арайхийн залгуулж байв. Тиймээс 300 гаруй монгол иргэн Итали дахь Монгол Улсын элчинд нутаг буцах хүсэлт удаа дараа гаргаж, Монголоос тусгай үүргийн онгоц ирэхийг харуулдан суудаг байсан гэхэд хилсдэхгүй. Италид суурьшин амьдардаг монголчууд элэг нэгт монголчууддаа чадах чинээгээрээ тусалж, гэртээ хүртэл хонуулж байлаа.

Харин Италид ажиллаж, амьдардаг монголчуудын хувьд бараг бүгд эндээ үлдэж хамтдаа цар тахлыг даван туулахыг илүүд үзсэн. Тэр дундаа Монгол руу коронавирус тээж очоод яах вэ гэх хүмүүс ч мэр сэр байсан санагдана. Азаар Итали улсаас бүх иргэдэд тодорхой хэмжээний мөнгөн тэтгэмж олгосноор хоолтойгоо залгаж билээ.

Өнөөдрийн байдлаар Европоос нийтдээ 2768 монголчууд эх орондоо буцах хүсэлтээ илэрхийлээд байгаа. Саяхан зургадугаар сарын 8-нд Монгол Улсын Онцгой комисс хоёр мянган иргэнээ тусгай үүргийн найман нислэгээр эх орондоо авчрахаар шийдвэрлэсэн ба Итали болон Мальтад байгаа иргэдийг зургадугаар сарын 19-ний Франкфурт-Улаанбаатарын нислэгт хамруулна гэсэн нь туйлын сайхан мэдээ.

Гэвч тусгай нислэгийн тийзний үнэ 800-1000 евро болно гэсэн нь харийн оронд зүдэрч буй иргэдэд хүнд тусаад байна.

Эдийн засагт үзүүлсэн нөлөө

Цар тахал нь Италийн эдийн засгийн 13 хувийг бүрдүүлдэг аялал жуулчлалын салбар, тэр дундаа зочид буудал, ресторан, үйлчилгээний байгууллагад том хохирол учрууллаа. Хөл хорио тогтоосон учир Итали руу ирэх жуулчид болон гадаад валютын урсгал зогссон. Гуравдугаар сарын 21-нд бүх жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг Италийн Засгийн газар гаргасан билээ.

2020 онд Италийн ДНБ долоон хувиар буурч, гадаад өрийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа жилийн эцэс гэхэд 130-аас 180 хувиар өснө гэж эдийн засагчид таамаглаж байна. Итали улс гадаад өр төлбөрөө барагдуулахын тулд хэцүү он жилүүдийг туулахаас өөр аргагүй боллоо. Мөн Италийн төсвийн алдагдал 2020 онд 11 хувьд хүрнэ гэсэн урьдчилсан тооцоог Европын хороо гаргасан. ►

- Цар тахлын үед Италийн өмнөд хэсгийн оршин суугчид хамгийн их хохирол амссан юм. Тухайн бүс нутагт хараар ажилладаг хүмүүс ажилгүйдлийн тэтгэмж авах эрхгүй байдаг учраас амь тэмцсээр. Италийн Засгийн газар 400 сая еврогийн өртгөөр ядуу иргэддээ хүнсний дэлгүүрээс хүнс худалдаж авах тасалбар хүртэл тарааж байсан юм. Сонирхолтой нь Италийн мафийн бүлгүүд өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст тусламж болгож хоол хүнс тарааж эхэлсэн. Энэ нь энэрэнгүй зан гаргасандаа бус оршин суугчдыг хяналтдаа байлгахыг эрмэлзсэн явдал гэсэн хардлага ч гарав.



эхэлсэн. Жуулчдаар тасардаггүй Opera рестораныг минь үйлчлүүлэгчгүй шахуу өдрүүд тойрч биш дайрч гардаг болжээ.

Би тавдугаар сарын сүүлчээр байрнаасаа нүүх шаардлагатай болж, шинэ байр хайж явахдаа жуулчдын хөлд дарагддаг байсан Венец хотын гудамжаар өнгөрсөн. Энэхүү гудамжаар хэдхэн итали хүн холхиж байгаа нь хуучны Италийн өнгө төрхийг санагдуулсан юм. Итали дахь гадаадын оюутнууд, жуулчид, бизнесмений тоо цөөрсөн учраас байрны түрээсийн үнэ огцом буурч, байр түрээслэгчид ихээхэн хохирчээ. Тиймээс Италийн Засгийн газар зургадугаар сараас эхлэн Европын орнуудаас ирэх жуулчдад хилээ нээх шийдвэр гаргасан юм.

Цар тахлын хүнд цаг үе дуусаж, Европын хамгийн алдартай аялал жуулчлалын хот Венец дахин жуулчдын хөлд дарагдах өдөр ойрхон байгаа гэж найдъя. Тэр үед би ч мөн адил дэлхийг тойрох аялалдаа эргэн гарах болно. ■



Хөл хориог суллав

Одоогийн байдлаар Италид 236,000 хүн коронавирусийн халдвар авч, 34,000 хүн нас барж, 169,000 хүн эдгэрсэн байна. Тавдугаар сарын 4-нд “Хоёрдугаар дугаар үе шат” нэртэй Ерөнхий сайдын тогтоол гарч, гэрийн хориог суллаж, зарим үйлчилгээний газрыг шат дараатай нээж эхэлсэн юм. Энэ тогтоолд нэг мужаас нөгөө муж руу зорчихыг хориглож, зөвхөн ажлын болон эрүүл мэндийн шалтгаантай хүн зорчихыг зөвшөөрсөн байна. Ихэнх үйлдвэр, барилгын үйл ажиллагааг эхлүүлж, ресторан болон үсчинг нээх боломжтой болсон билээ.

Хөл хориог суллахад миний ажилладаг Opera ресторан эхлээд хоол хүргэх үйлчилгээ үзүүлдэг байсан ба аажмаар үйлчлүүлэгчдийг хүлээн авч





Сингапурын Үндэсний их сургуулийн дэргэдэх Инновац 4.0 эрдэм шинжилгээний хүрээлэнд дата аналитикс төслийн менежер, Дэлхийн банкны Сингапур дахь дэд бүтцийн хаб-д зөвлөх, Монголын Бизнесийн зөвлөлийн Сингапур дахь төлөөлөгчөөр ажилладаг. Ли Куан Ю-гийн нэрэмжит нийгмийн бодлогын магистр, BoP Hub сошиал энтэрпрайзын экосистем хөгжүүлэх ажлыг мөн удирдан явуулж байна.



Б. ТЭМҮҮЛЭН

Хилийн чанадад ажиллаж, хөдөлмөрлөдөг иргэдийнхээ үнэ цэнийг ойлгоосой



Ковид-19 ба Сингапур

2020 оны нэгдүгээр сарын 23. Энэ бол Сингапурт жуулчилсан БНХАУ-ын иргэнээс коронавирусийн анхны тохиолдол илэрсэн өдөр. Энэ өдрөөс хойш Сингапур дахь нөхцөл байдал, хүмүүсийн амьдралын хэв маяг орвонгоороо өөрчлөгдсөн юм. 2020 оны тавдугаар сарын 19-ны байдлаар Сингапурт Ковид-19-ийн 28794 тохиолдол илэрсэн бөгөөд вирусийн тархалтыг хэзээ тогтоон барих нь бусад улс орны адил тодорхойгүй байна.

Тус улс нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс аж ахуйн нэгж, сургуулиудаа маш сайн ариутгал, онцгой хяналтын дор ажиллуулж гурван сарыг өнгөрүүлсэн. Гэвч вирусийн дэгдэлтийг тогтоон барихад хөл хорио тогтоох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тул дөрөвдүгээр сарын 7-ноос өндөр дэглэмтэй хөл

хориог улс даяар тогтоож, хүний хөлд үргэлжийн дараатай байдаг гудамж талбай, дэлгүүр хоршоо, спорт цогцолбор, хүүхдийн тоглоомын талбай, бизнес, сургууль цөм хаагдаж, гадуур ганц нэгээрээ явах, гэрээсээ хол сэлгүүцэхгүй, айлд зочлохгүй, уулзахгүй байх хязгаарлалтыг зургадугаар сарын 1 хүртэл тавив. Халдварын ихэнх тохиолдол анх гаднаас авчирсан сингапур иргэдээс илэрч байсан нь Монголын одоогийн нөхцөлтэй адил. Гэвч халдварыг нэг гадагш алдвал хэр хурдан тархдагийг бид Сингапур тэргүүтэй олон улсын туршлагаас харж буй учир үүнээс сургамж авч, төр засаг маань хяналтаа, ард иргэд маань анхаарал болгоомжоо сулруулахгүй байх нь зүйтэй.

Сингапурт гудамж талбай хов хоосон. Дэлгүүр хоршоо дийлэнх нь хаалттай. Гадуур хааяа нэг маск зүүсэн эсхүл гүйж яваа хүн үзэгдэх.... Та бидний төсөөлөлд буудаг Сингапур сүүлийн хоёр сарын хугацаанд ийн орвонгоороо өөрчлөгдлөө. Нийтийн тээвэр, гудамж талбайд хүмүүс хоорондоо дор хаяж нэг метр зай барих журмыг баталснаар сандал суудал бүрт, дэлгүүрийн очерт зориулж шалан дээр хүртэл тэмдэглэгээ хийв. Биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, гүйх, дугуй унах зэргээс бусад тохиолдолд амны хаалт байнга зүүж явах төдийгүй цөөн хэдэн онгорхой хүнсний дэлгүүр, шатахуун түгээгүүр, эмнэлэг зэргээр орж гарах бүртээ оршин суух цахим үнэмлэхээрээ цагийн бүртгэл хийлгэх ёстой. Ингэснээр халдвартай иргэн зорчсон газруудыг түргэн хугацаанд тогтоохоос гадна тухайн газар хэн явж байсныг нарийвчлан тогтоох боломжтой гэж албаныхан үзсэн.

Шинээр тогтоосон хязгаарлалт, дүрэм журмыг сахиулахаар сайн дурын ажилтанг олноор ажиллуулж байгаа бөгөөд зөрчил гаргасан ▶

► иргэд, албан газруудад өндөр торгууль, шийтгэл хүлээлгэнэ. Жишээлбэл, зөрчлийн хэлбэрээс шалтгаалаад хөнгөн тохиолдолд хувь хүн зөрчил гаргавал эхний удаа 300 сингапур ам.доллараар торгож байна. Харин давтан зөрчил гаргасан хүнд хорих ял оноохоос гадна хүний өөрийн гэлтгүй тус улсад оршин суух эрхийг цуцлах арга хэмжээ авч байна.

Сайны хажуугаар саар гэгчээр энэ цар тахал тус улсад чимээгүй оршдог хүний эрхийн асуудал болох гадаад ажилчдын хөдөлмөрийн хүнд нөхцөлийг бүх нийтийн анхааралд оруулав. Тус улсад ойролцоогоор 300 орчим мянган гадаад хөлсний ажилчин ажилладаг бөгөөд өнөөдрийн байдлаар 12 хөлсний ажилчин тутмын нэг нь коронавирус туссан байгаа нь олны эгдүүцлийг төрүүлж байна. Дотуур байран дахь ажилчдыг олноор нь тусгаарлаж эхэлснээр барилгын ажлууд, гудамж талбай тохижуулалт, цэвэрлэгээ үндсэндээ зогссон байдалтай байна.

Сингапур дахь монголчууд

Миний хувьд гэр бүлийн хамт Сингапурт амьдардаг ба бага насны хүү, охин хоёртой. Том хүү маань энэ энэ жил нэгдүгээр ангид орсон ч цар тахлын улмаас гэрээсээ хичээллээд даруй хоёр сар өнгөрчээ. Хүүхдэд суурь боловсрол олгох, сурган хүмүүжүүлэхэд ямар их тэсвэр тэвчээр, ур ухаан шаарддагийг энэ хугацаанд ойлгож ухаарах завшаан тохиов. Аль ч улс багш, сурган хүмүүжүүлэгч нарынхаа хөдөлмөрийг өндрөөр үнэлэх хэрэгтэй. Ялангуяа суурь боловсрол, сурах төлөвшил олгодог бага ангийн багш нарыг энд онцлон хэлмээр байна.

Ажлын газрын хувьд бүх албан томилолтыг цуцалж, Ковид-19-тэй холбоотой лабораторийн ажлаас бусад бүх үйл ажиллагаа гэрээс ажиллах горимд шилжсэн байна. Бид өдөрт хоёр удаа халуунаа хэмжиж, коронавирусын шинж тэмдэг илэрсэн эсэхээ цахимаар бүртгүүлдэг бөгөөд эх орондоо буцахаас бусад тохиолдолд өөр улс оронд зорчихгүй байх удирдамж авсан. Бидний бие болоод сэтгэлзүйн эрүүл мэндэд зориулж цөөнгүй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд эрүүл өөдрөг амьдрах ухаан, гэрээс ажиллахад цагаа зөв зохицуулах талаар байнгын зөвлөмж илгээж, хэрэгтэй нэгэнд нь сэтгэлзүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн хүмүүсийг мөн ажиллуулж байна.

Ковид-19 цар тахлын улмаас Зүүн Өмнөд Азийн улс орнуудад сурч, ажиллаж, эмчлүүлж,

жуулчилж байсан 400 гаруй монголчууд гацсан бөгөөд нөхцөл байдал дээрдэхийг горьдож, эх орон маань татаж авахыг тэсэн ядан хүлээж сууна. Миний холбогдсон хилийн чанадад суугаа хүмүүс хатуу дэглэмтэй хорионд ороод 40-100 хонож байна. Зарим нь орох оронгүй, төлбөрийн чадваргүй маш хүнд нөхцөлд өдөр хоногийг өнгөрүүлж байна. Урт хугацаанд үргэлжилж байгаа (цаашид ч үргэлжлэх) энэ нөхцөл байдал ямар ч хүний бие сэтгэцийн хувьд маш том сорилт юм.

Энэ талаар Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Т.Лхагвадоржтой холбогдож лавлахад Сингапур Улсаас эх орондоо буцахаар 80 орчим хүн албан хүсэлт гаргасан бөгөөд ЭСЯ-ны зүгээс тэдгээр хүсэлтийг цаг алдалгүй ГХЯ-нд хүргүүлж, иргэддээ олон талаар дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа аж. Тухайлбал, монгол иргэдийнхээ визийг сунгуулах асуудлыг Сингапурын төр засгаар шийдвэрлүүлж, Сингапур Улсын Цагаачлалын албанд хандахад нь туслалцаа үзүүлж байгаа төдийгүй хоол хүнсний хэрэгцээнд нь дэмжлэг үзүүлэх буяны байгууллагуудтай холбож өгч байна. Мөн Сингапур дахь зочид буудлууд гадаад иргэдийг хүлээж авахгүй байгаагай холбогдуулан ►



► ЭСЯ-аас албан шугамаар хөөцөлдсөний үр дүнд монгол иргэд маань зочид буудалд хөнгөлөлттэй буух боломжийг нээж өгчээ. Түүнчлэн Сингапураас Монгол Улсад шинжилгээний төхөөрөмж хандивлах ажлыг зохион байгуулж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд Темасек сангаас 3000 төхөөрөмж илгээж, Монгол Улсад бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, хөрөнгө оруулагч нарын хандиваар 1800 шинжилгээний тест Монголд илгээхээр ажиллаж байгаа аж.

Ковид-19-тэй тэмцэж буй Сингапурын түршлага



Сингапурын хувьд сүүлийн 20 жил хөгжүүлсэн биотехнологи, үйлдвэрлэлийн салбартаа түшиглэн маск, шинжилгээний тоног төхөөрөмж зэрэг нэн шаардлагатай багаж хэрэгслийг үйлдвэрлэж дотоодын хэрэгцээгээ хангахаас гадна шинжилгээний тоног төхөөрөмжөө экспортолж байна. Мөн 28 мянга гаруй хүн халдвар авсан гэхэд 20 орчим хүн (өндөр настай, суурь өвчтэй хүмүүс) нас барсан статистикийг бусад хөгжингүй орнуудын тоо баримттай харьцуулбал тус улсын анагаахын салбарын хөгжлийн түвшинг илтгэнэ.

Коронавирустэй тэмцэх түүнчлэн уг цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралыг тогтоон барих, иргэдийн орлогын тогтвортой байдлыг хангах зорилгоор тус улс 33.7 тэрбум ам.долларын (ДНБ-ий 12%-тай тэнцэхүйц) төсвийг батлав. Энэхүү төсвийг бүрдүүлэхэд улсын сан хуримтлалаасаа санхүүжилт татсан бөгөөд сан хөмрөг рүүгээ

орох нь тус улсын хувьд маш ховор үзэгдэл юм. Уг төсвөөс иргэн бүртээ 420 орчим ам.доллар тарааж буй бөгөөд энэ нь ажиллах, оршин суух эрхтэй бидэн шиг гаднын иргэдэд огт хамааралгүй. Мөн тэд ажилгүйдэлд нэрвэгдсэн иргэддээ зориулж төрийн түр албанд 10 мянган шинэ ажлын байр бий болгохоо зарласан.

Мөн хувийн компаниудын эргэлтийн хөрөнгөд нь зориулж нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгож, төрийн өмчит үл хөдлөх хөрөнгөд суугаа түрээслэгч нарыг түрээсийн төлбөрөөс чөлөөлж, бусад түрээслүүлэгч нарт татварын хөнгөлөлт олгох замаар түрээс төлөгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж эхлэв. Чингэхдээ түрээслүүлэгч түрээслэгчийн төлбөрийг хөнгөлөөгүй тохиолдолд хуулийн хариуцлага хүлээхээр зохицуулалт хийж өгчээ. Үнэхээр тал талаас нь харсан гайхалтай цогц шийдлүүдийг хэрэгжүүлж байгааг хараад биширснийг нуух юун.

Гадаад дахь монголчууд

Хэдий Монголын төр засаг нийтийн эрх ашгийг хамгаалж, хилээ хаасан ч хилийн чанадад ажиллаж хөдөлмөрлөдөг иргэдийнхээ үнэ цэнийг санаж, энэ хүнд нөхцөлд илүү их нөөц бололцоог дайчлах хэрэгтэй мэт санагдана. Бид бүгд мартсан байж болох нэг тоог энд дурдья гэж бодлоо. Хилийн чанадад суугаа монголчууд эх орныхоо эдийн засагт жилд хэдэн зуун тэрбум төгрөгийг тасралтгүй төвлөрүүлж ирсэн. 2018 онд л гэхэд нэг их наяд төгрөгийг эх орондоо илгээжээ. Үндэсний явдаг томоохон групп компани эсхүл экспортлогчийн дайтай валютыг эдийн засагтаа оруулж байдаг гэсэн үг.

Гадаадаас бидний илгээдэг энэ бүх шилжүүлэг дотоодын эргэлтэнд орж та бидний амьдралд шууд болон шууд бусаар эерэгээр нөлөөлж олон хүний амьдралд дэм болж ирсэн гэдэгт эргэлзэхгүй байна. Хилийн чанадад суугаа монголчууд бол манай улсын эдийн засгийн нэгэн тулгуур гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу. Иймд засгийн газар маань үүнийг харгалзан үзэж, нарийн зохион байгуулалттайгаар иргэдээ татан авах ажиллагааг эрчимжүүлэхийг хүсэхийн сацуу эх орондоо суугаа хүмүүстээ хандаж сайн цагийг эргэн санаж гадаадад суугаа иргэдээ хүлээн авахад уужуу хандахыг уриалья. Эцэст нь сайн сайхан цаг эргэн ирж эх орон, төрөлх нутагтаа дэлгэр зуны цагт уулзахын ерөөл тавин энэхүү тэмдэглэлээ өндөрлөө. ■



Увс аймгийн Улаангомд төрсөн. Монгол судлаач. “Чанадаас халих бясалгалын төв” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагад багшилдаг.



Э.ЮМЧИН

10 мянган монголчууд минь эх нутагтаа хурдан хариасай гэж залбирч сууна

Тайландын Хаант Улсын тухай товчхон

Тайланд улсыг товчхон танилцуулбал, Энэтхэг-Хятадын хойгт Мьянмар, Лаос, Камбож, Малайзтай хуурай газраар, Вьетнам, Индонез, Энэтхэгтэй далайгаар хиллэдэг, дэлхийд хүн амын тоогоор 22-т ордог (69 сая гаруй), хамгийн тослогтой, шим тэжээлтэй будаа, сайхан амтат жимс тарьдаг үржил шимт өргөн уудам уул талтай, газар нутгийн хэмжээгээр дэлхийд 50-д (513120 км2) ордог, нийт 76 чангват буюу манайхаар бол аймагтай юм.

Нийслэл Бангкокоо 2013 онд аймгийн статустай болгосон, 1932 оноос Үндсэн хуульт хаант засагтай болсон (хааныхаа зургийг айл, албан байгууллага бүр бурханчлан шүтдэг), хүн амын 94,5 хувь буддын шашин шүтдэг. 2019 оны байдлаар ДНБ-ий хэмжээ 516 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд (нэг хүнд ногдох ДНБ нь 7607), инфляц 3,2 хувь байсан. Ханшийн хувьд нэг ам.доллар 32 багтай тэнцдэг юм.

Сүүлийн 30 гаруй жил асар хурдтай хөгжиж байгаа энэ улсын гадаад өр маш бага, ядуурлаас бараг ангижирсан, зам, харилцаа сайтай. Японы ихэнх автомашин, электроникийн брэндүүд энд үйлдвэртэй гэх мэтээр үйлдвэрлэлийн салбар нь сайн хөгжсөн, харьцангуй хямд боловч боловсролтой ажиллах хүчинтэй, эдийн засагт нь хөдөө аж ахуй дутахгүй чухал байр суурь эзэлдэг. Сонирхолтой нь, төр захиргааны ажилтнуудыг “авлига ав, гэхдээ улсаа хөгжүүл” гэсэн далд бодлоготой тул иймэрхүү болон өөр бусад таагүй үзүүлэлт ч чамгүй их бий.

Тайландын Засгийн газар 1982 онд жуулчдын аюулгүй байдлыг хангахын тулд санал гомдлыг нь бүртгэн авч, асуудлыг нь хариуцаж (утас нь 1669) ажилладаг аялал жуулчлалын цагдаагийн



газрыг байгуулж боловсрол, хэл устай цагдаа нар бэлтгэсэн.

Цар тахлын үеэрх Тайланд

Зургадугаар сарын 8-ны байдлаар тус улсад халдварын 3119 тохиолдол бүртгэгдээд байгаагаас 2973 хүн эдгэж, 58 хүн нас барж, 88 хүн эмчлүүлж байна. Сүүлийн өдрүүдэд зөвхөн гаднаас зөөвөрлөгдөн орж ирж байгаа. Миний суралцаж байгаа Чантхабурид Бангкокийн нисэх буудлаас хүн зөөдөг таксины жолооч зэрэг гурван хүнээс халдварын тохиолдол олон хоногийн өмнө илэрсэн. Одоогоор нэмж халдвар авсан хүн алга.

Ковид-19-ээс шалтгаалж жуулчлал, бизнес, хөдөө аж ахуйн салбар хүнд цохилт амссанаар Тайландад нийгэм, эдийн засгийн нэн хүнд байдал үүсэж, нийт долоон сая хүн ажлаас халагдах, нэмээд ажиллах хүчний 54.3 хувь болох 20,4 сая хууль бус ажилчид ажилгүй болох эрсдэл үүсээд байна. ►

► Дөрөвдүгээр сарын 15-ны байдлаар Ковид-19-ийн эрсдэлээс сэргийлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулбал:

- Хөл хорио тогтоож, олон улсын нислэгийг зургадугаар сарын 30 хүртэл зогсоосон.
- Засгийн газраас нэг их наяд батын зээл олгохоор шийдвэрлэсэн. Хөдөө аж ахуй, эрүүл мэнд зэрэг тодорхой салбарын ажилтнуудад 3-6 сарын турш сар тутам 5000 бат олгоход 600 тэрбум, мөн бүс нутгийн асуудлуудыг шийдэхэд 400 тэрбумыг зарцуулах юм.
- Тайландын Төв банк 500 тэрбум батыг маш бага буюу хоёр хувийн хүүтэйгээр арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлэх, зургаа хүртэлх сараар хүүг царцаах хөтөлбөр хэрэгжүүлж байна. Төв банк нь бодлогын хүүгээ

- Цар тахлын улмаас ажилгүй болсон иргэдийн өдрийн орлогын 62 хувийг нийгмийн халамжийн сангаас олгоно. Нийгмийн даатгалын шимтгэлийг гурваас тавдугаар сарын хооронд ажил олгогчийн хувьд дөрөв, ажилтнуудын хувьд нэг хувь болгож бууруулсан.
- Татвараа 2020 оны 4-9-р сард 3-аас 1,5, 10-р сараас 2021 оны 12-р сар хүртэл 2 хувь болгох шийдвэр гаргасан.

Гуравдугаар сарын 16-нд халдварын тохиолдлын тоо 147 болонгуут 50-аас дээш хүн цуглардаг газруудыг тодорхойгүй хугацаагаар хаах, дөрөвдүгээр сарын 13-нд тохиосон Сонгкран уламжлалт баярыг хойшлуулах, гуравдугаар сарын 26-наас дөрөвдүгээр сарын 30 хүртэл улс орон даяар онцгой байдал тогтоох шийдвэрийг Засгийн газар нь гаргаж, түүнээс хойш сунгасаар долдугаар сарын 1-нд хөл хориог цуцлахаар төлөвлөж байна.

Тайланд дахь монголчууд

Миний хувьд мэдэхгүй, танихгүй газар ирээд 234 хоночихжээ. Ямартаа ч усыг нь ууж ёсыг нь дагаад, тусгай вакум цогцолборт хичээл, бясалгалтай завгүй байсаар зургаан сарын сургалтаа дүүргээд дөрөвдүгээр сард буцчих байтал хариагүй л сууж байна. Нэлээдгүй олон орноор явсан бясалгаач Тай эмэгтэй манайхыг лалын шашинтай гэж боддог байсан гэдгээс харахад Монголын талаар ер нь мэддэггүй бололтой. 20 гаран насны охиноос Ковид-19-ээс болоод Чантхабурид амьдрал ямар болов гэхэд өөрчлөгдсөн юмгүй л гэх юм.

Тайландад суурин амьдардаг монголчууд танихгүй хүнд аж амьдралаа дэлгэхгүй нь ойлгомжтой тул аль болох хурдан харих хүсэлтэй байгаа 159 монголчуудын тав, гурваас сурвалжилсан нөхцөл байдлаас дуулгая. Дамжин өнгөрч яваад гэнэт хил хаагаад онгоцонд суулгүй хоцорсон, эндээс шууд нислэгтэй байсан болохоор Өмнөд Азийн бусад орныг бодвол харих боломжтой гэсэн найдвар тээж хил хаахаас өмнө, хойно яаж ийгээд ирсэн, олон улсын уралдаан тэмцээнд оролцсон, сургалт, сургуулиа төгссөн, оношлуулах эмчлүүлэх гэх мэт зүсэн зүйлийн шалтгаантай хүмүүсийн мөнгө төгрөг нь дуусаад ар гэрийнхнэ нь яаж ийгээд өдрийн хоол, байрны хөлс залгуулах, над мэт нь хандив зээл гуйх, бөгчим халуун цаг агаар зэрэг түмэн шалтгаанаар өдөр ирэх тусам бидний ахуй ►



нэг хувь болгох шийдвэрийг гуравдугаар сард гаргасан.

- Тайландын Төв банк ДНБ-ий өсөлтийн таамгаа нэмэх 2.8-аас хасах 5.3 хувь болгож бууруулсан нь 1997 оны Азийн санхүүгийн хямралаас хойших хамгийн муу үзүүлэлтэд тооцогдож байна.
- Дотоодын бондын зах зээлийг дэмжих, улмаар аж ахуйн нэгжүүдийн зээлжих зардал өсөхөөс сэргийлэх үүднээс Бондын тогтворжуулалтын сан байгуулж, 400 тэрбум бат хуваарилав.

► хүндэрсээр байна. Эхэндээ арай гайгүй байр нийлж хөлсөлж байсан бол одоо умгар ганц өрөөнд олуулаа өдөртөө чанартайдуу ганц хооллох санаатай байдаг болов.

Байрны мөнгөгүй гудамжинд гарсан нэгнээ хажуудаа чирээд явах сайхан сэтгэлтэн байхад айлд байгаа хэрнээ юм хумслаад, тусалсан нэгнээ цагдаад дуудуулаад төвөг удах нэг нь ч байна. Хумслаад гэснээс, энд монгол гэхээр хулгайч гэж боддог гэж сонсоод монгол гэдгээ хэлэхгүй байгаа гэхийг сонсоод шогширмоор. Нэг үхрийн эвэр дэлсвэл 1000 үхрийн эвэр доргино гээч болсон байх магадлалтай ч гадаадад гарахаараа та Монгол улсын элч, элчин, тод томруун төлөөлөл болдог гэдгээ бат санаж явууштай.

Монголын төр долдугаар сарын 1-нээс бэлтгэлээ сайтар хангаад хилээ монголчууддаа нээгээсэй, ядахдаа Солонгосын онгоцыг Улсын онцгой комисс хүлээж аваасай, Тайланд бас олон улсаас нислэг хүлээж авдаг болоосой, энэ бүхэн бүтэхгүй байсан ч гэсэн Гадаад харилцааны яамныхан эртхэн шиг тохиролцоод Бангкок мөнгөн цагаан хүлэг минь нисэж ирээд нэн яаралтай харих шаардлагатай болчихоод байгаа монголчуудаа бүгдийг нь хуу хамаад явчихаасай, 10 мянган монголчууд минь эх нутагтаа хурдан хариасай гэж залбирч болдог бүхэнд залбирч, хүсэж болдог бүхнээс хүсэж, биелүүлэхийн тулд чадахаасаа чадахгүйгээ хүртэл алхана даа хэмээн бодолхийлж сууна.

Тайландын аялал жуулчлал

Тус улсын аж амьдрал, бизнес шууд болон шууд бус утгаараа аялал жуулчлалын салбартай бараг 60 хувь холбоотой тул 2020 оны эдийн засгийн нөхцөл байдлыг ойлгуулах үүднээс нэг арлын тухай цухас дурдъя.

Пукетын дараа ордог хоёр дахь том арал болох Ко Самуйд (Koh Samui) аялал жуулчлал 1980 он гэхэд эдийн засгийнх нь чухал хэсэг болсон бөгөөд Сурагани аймагт харьяалагдаж байгаад 2008 оноос тусдаа статустай болжээ. Мэдээж бусад газрын нэгэн адил жуулчдыг татах, үйлчлэх бүхнийг цогцлуулсны дээр Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны бодлого, хувийн хэвшлийн ачаар дээд зэрэглэлийн зочид буудал, үйлчилгээний газрууд байгуулж тохижуулсан байдаг. Паттаягаас хоёр дахин үнэтэй шахам энэ газар 2015 оны байдлаар 17938 зочид буудлын өрөөтэй, олон

улсын арга хэмжээ, өвөрмөц наадам хийж болох газруудтай, жил бүр хийдэг баяр, арга хэмжээ олонтой, 2017 онд л гэхэд 2,5 сая гадаадын жуулчин хүлээж авч байв. Буудлын өрөөний үнэ өдрийн нэг сая төгрөгийн үнэтэй таван одтой буудлаас дээш, доошоо хэлбэлзэнэ. Энд үйлчилгээ, харилцаа маш сайтай, таарсан хүн бүр нь тусархаг, инээмсэглэн харилцаж, алга хавсарч мэндлээд л, нохой нь хүртэл хуцаж боргодоггүй гэж байгаа.



Байр үнэтэй ч хоол нь хямд, төрөл төрлөөрөө алаглана. “Теско”-д шинэ ургацын манго дөрвөн кг нь 100 бат буюу 9000 гаруйхан төгрөг. Нэг ширхэг наргил самар Бангкок 170, Самуйд 30 (миний байгаа Чантхабури аймгийн төвд 40) бат байх жишээтэй. Жимс, далайн гаралтай хүнс нь органик, шинээрээ, машинтайгаа шууд авчраад зарчихдаг. Гудамжаа хаагаад оройн сэрүүнд гар урчууд нь тааран хувцас, цүнх, гоёл чимэглэл, сувд зэргээ дэлгэнэ. Аквариумтай загаснаас бариулаад шарах, гриллдэх мэтээр хүссэнээрээ болгуулж зооглох юм уу, галын өрөөтэй бол шинэ загас аваачаад шөл хийж идэх гэх мэт тансаглаж болно. Одоо хоосон, хүнгүй шахуу байгаа болохоор ихэнх зочид буудал 50 хувь хямдарсан. Сарын 75000 бат байдаг “Jungle Villa” буудал сайн ярьвал 25000 бат хүртэл буух боломжтой болжээ.

Ковид-19-ээс шалтгаалж энэ аралд л гэхэд 100 орчим зочид буудлыг зарахаар зар тавиад байгаа аж. Наран шарлага нь хөл тавих зайгүй шахам байсан бол одоо энд гацсан 20 орчим жуулчин өдөртөө үзэгдэж байна. ■




Улаанбаатар хотод төрсөн. Франц улсад мэдээллийн системийн мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан. Эдүгээ тус улсын банкны салбарт тэргүүлэгч "BPCE" группын харьяа "Natixis" компанийн даатгалын хэсэгт дата аналитаар ажиллаж байна.



Б.ДЭЛГЭРМАА

Эдийн засгийн өсөлтөөс ч чухал зүйл



Өглөө 7-9 цагийн хооронд хүмүүс метронд чихэлдэж, ажил дээрээ ирмэгцээ бие биеэ үнсэн хоорондоо мэндчилж, өдрийн хоолны цагаар хооронд нь ойрхон зассан зоогийн газрын ширээн дээр тохой нийлүүлэх шахам хооллож, ажил тарах цагаар мөн л дүүрэн хүнтэй метронд суугаад харина.

Парис хэмээх их хотын үдшийг хүний хөл тасардаггүй гудамж талбай, парисчууд болоод жуулчид холхих худалдаа, үйлчилгээний газрууд, ихэвчлэн дүүрэн хүнтэй урлагийн тоглолт, концертууд, гадаа нь удаан дугаарлаж байж орох баар ресторанууд, үргэлж битүү хүнтэй байдаг кафе террасгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. 2020 оны гуравдугаар сарын эхэн хүртэл Парист амьдрал урьдын адил ийн хэвийн үргэлжилж байлаа.

Хятад болоод Азийн зарим оронд Ковид-19-ийн халдвар газар авч, нөхцөл байдал хүндэрч байгаа тухай мэдээ өдөр бүр чих дэлсээр байхад ч, нэгдүгээр сарын 24-нд коронавирүсийн халдвар

авсан анхны гурван хүн Парис, Бордо хотод бүртгэгдэхэд ч, хоёрдугаар сарын 15-нд Францад коронавирүсээр өвчилсөн анхны хүн нас барахад ч Парист амьдрал он удаан жил ямар байв, тийм л янзаараа үргэлжилсээр байв.

Гэнэт зарлагдсан хатуу хөл хорио

Францчуудын амьдралын энэ хэв маягийг эвдэж, Ерөнхий сайд Эдуар Филипп гуравдугаар сарын 14-ээс эхлэн цэцэрлэг, сургууль болоод олон нийтийн зарим байгууллагыг хаах шийдвэрээ танилцуулсан нь Францад халдвар авсан хүний тоо даруй 5000 давж, энэ вирүсээр нас барсан хүний тоо 100 хол гарсантай

холбоотой байлаа.

Энэ мэдэгдлээс хэдхэн хоногийн дараа буюу гуравдугаар сарын 17-ны өдрийн 12 цагаас эхлэн улс орон даяар хөл хорио тогтоож буйгаа Францын ерөнхийлөгч Эммануэль Макрон зарласан юм. Энэ өдрөөс Шенгений хил хаагдаж, хүнсний дэлгүүр, авто засвар, оршуулгын үйлчилгээ явуулдаг газар зэрэг цөөн тооны аж ахуйн нэгж, байгууллага нээлттэй үлдэж, бусад бүх компани ажилчдаа гэрээс нь ажиллуулах боломжгүй тохиолдолд үүдээ барьсан билээ.

Эрүүл ахуйн онцгой дэглэмтэй, хөдөлгөөний хязгаарлалттай энэ хатуу хөл хорионы үеэр зөвхөн хоол хүнсээ цуглуулах, эрүүл мэндийн шаардлагаар эмнэлгийн байгууллага руу явах, гэрээсээ ажиллах боломжгүй тул ажилдаа явах, амьдардаг газраасаа нэг километрээс холгүй, дээд тал нь нэг цагийн турш ганцаараа биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, гэрийн тэжээвэр амьтдаа салхилуулах зэрэг зайлшгүй хэрэгцээтэй тохиолдолд л гэрээсээ гарч байв. Түүнчлэн гарах бүртгээ иргэний үнэмлэхээс ▶

► гадна тусгай маягт бөглөж, биедээ байнга авч явах ёстой ба энэ дүрмийг зөрчсөн тохиолдолд 135 еврогийн торгууль ноогдуулах заалттай.

Хөл хорионы үеэр тогтоосон дүрэм, журмыг мөрдүүлэхээр 100 мянга гаруй цагдаа ажиллаж байв.

Аниргүйн дундах алга ташилт

Маш хатуу хөл хорио тогтоосны улмаас ийнхүү аниргүй, хоосонд живсэн Парис хотыг өдөр бүр сэрээдэг зүйл нь орой найман цагт эмч, эмнэлгийн байгууллагынханд талархлаа илэрхийлэх бүх нийтийн нижигнэсэн алга ташилт байв. Цонхоороо, тагтан дээрээ, байрныхаа доор, байшингийнхаа цэцэрлэгт гээд хүмүүс энэ хэцүү үед өөрийн эрүүл мэнд, амь насыг эрсдэлд оруулан тангарагтаа үнэнч зүтгэсээр байгаа эмч, сувилагч нарт талархал илэрхийлдэг байсан юм. Энэ нь тэдэнтэй нэгдмэл байгаа гэдгээ харуулах нэг илэрхийлэл байлаа.

Сэтгэлээрээ ойр байгаагаа ийн харуулахаас гадна эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг дэмжсэн хувь хүн, жижиг, дунд байгууллагуудын олон санал санаачилгууд гарсан. Тухайлбал, өөр хотоос нэмэлт хүч болж ирсэн эмч, сувилагч нарыг 4, 5 одтой зочид буудлууд үнэгүй байрлуулж, таксины жолооч нар буудал, ажлынх нь хооронд үнэгүй тээвэрлэж, эмнэлгийн гуанзны ачааллыг багасгах зорилгоор ресторан, дэлгүүрүүд хоол хүнс өдөр бүр хүргэж, маскийн нөөцтэй албан байгууллага, хувь хүмүүс бүх нөөцөө тэдэнд хандивлаж, сайн дурын багш нар эмнэлгийн ажилтануудын хүүхдүүдийг өдөржин харж өгч байсан юм.

Коронавирусийн халдварын оргил үе болох дөрөвдүгээр сарын эхэнд том хотуудын ихэнх эмнэлэг ачааллаа дийлэхээ больсноос жижиг хотуудын эмнэлэг рүү зарим өвчтөнөө шилжүүлэх, эсвэл тэдгээр эмнэлгээс эмч, сувилагчдыг нь нэмэлт хүч болгон авчрах зэрэг арга хэмжээ авч байв.

Тэгтэл зөвхөн Франц дотроо ч биш Европын холбооны улсууд ч бие биедээ тусалж, Францын хэд хэдэн хүнд өвчтөнийг Герман, Люксембург, Швейцарь улс өөрсдийн эмнэлэгт шилжүүлэн авч, эмчилсэн юм.

Эдийн засгийн өсөлтөөс ч чухал зүйл

Францын үндэсний уриа нь “эрх чөлөө, тэгш эрх, эв санааны нэгдэл” бөгөөд их, бага хэмжээгээр эмнэлгийн байгууллагынханд дэмжлэг болох

гэсэн эдгээр үйлдэл нь тэднийг хэр эв нэгдэлтэй, бие биеэ гэсэн сэтгэлтэй болохыг харуулж байлаа.

Мөн Засгийн газар нь иргэдээ энэ хүнд цаг үеийг амгалан давахад бүх нөөц бололцоогоо ашиглан дэмжиж байсныг онцолмоор байна.

Хөл хорионы үеэр үйл ажиллагаа нь зогссон эсвэл хумигдсан байгууллагын ажилтнуудад цалинтай чөлөө олгох шийдвэр гаргаж, хэрэв цалингийн доод хэмжээгээр (татварын өмнөх байдлаар сарын 1539 евро) цалинждаг бол бүтэн цалинг, бусад тохиолдолд цалингийн 84 хувийг улсаас өгөхөөр шийдвэрлэсэн. Энэ шийдвэр нь гадаад, дотоодын гэж ялгаагүй, ажлын гэрээтэй бүх хүмүүст хамаатай байв. Нийт есөн сая орчим хүн энэ үеэр цалинтай чөлөө авсан ба улсаас нийт 24 тэрбум орчим еврог үүнд зарцуулжээ.

Төрөөс зохион байгуулалттай авсан энэ арга хэмжээний ачаар олон хүн компанийнх нь үйл ажиллагаа доголдсон эсвэл түр зогссоны улмаас ажлаа алдах эрсдэлээс аврагдсан юм. Мөн ажиллаагүй үедээ шинэ чадвар эзэмших, эсвэл мэргэжил дээшлүүлэх богино хугацааны онлайн сургалтад суух хүсэлтэй бол улсаас сургалтын зардлыг нь дааж байлаа.



Түүнчлэн үйл ажиллагаа нь хэвийн үргэлжлэх боломжгүй бүх жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 1500 евро олгож, тэр дундаа хүнд нөхцөлд орсон бизнес эрхлэгчдэд 5000 хүртэлх еврогийн нэмэлт тусламж үзүүлэх, ус, цахилгаан, түрээсийн төлбөр болоод татвар төлөх хугацааг торгуульгүйгээр хойшлуулах, шаардлагатай нөхцөлд чөлөөлөх, бизнес эрхлэгчдэд сэтгэлзүйн үнэгүй зөвлөгөө өгөх арга хэмжээ авч байв. ►

► Мөн 300 тэрбум еврог жижиг, дунд компаниудын эргэлтийн хөрөнгөд зориулж тусгай нөхцөлтэй, хөнгөлөлттэй зээлээр олгохоор төсөвлөөд байна. Эдгээр арга хэмжээний ачаар мянга, мянган жижиг, дунд бизнес эрхлэгч компаниа дампуурлын ирмэгээс аварч чадсан.

Хэвийн байдалдаа эргэж оров

2020 оны зургадугаар сарын 3-ны байдлаар Францад нийт халдвар авсан хүний тоо 152 000, эдгэрсэн хүн 69 455, нас барсан хүний тоо 29 021-д хүрээд байна.

Францын Засгийн газар тавдугаар сарын 11-ний өдрөөс эхэлж, хөл хориог хэсэгчлэн сулруулах шийдвэр гаргасан. Энэ шийдвэрийн хүрээнд өвчний тархалт бага мужуудад зарим сургууль нээгдэж, нийтийн тээврийн үйлчилгээ сэргэж, жижиг дэлгүүр, худалдааны төвүүд онгойж, далайн эрэг, цэцэрлэгт хүрээлэн зэрэг амралт, зугаалгын газруудыг хотын захирагчид нь зөвшөөрвөл нээж, ард иргэд 100 километрээс дотогш явах тохиолдолд тусгай маягт бөглөхгүй байх зэрэг эерэг өөрчлөлт гарсан ч Европын холбооны хил хаалттай хэвээр үлдлээ. Харин вирусийн тархалт өндөртэй Парис зэрэг хотод сургууль, амралт зугаалгын газруудыг эхний шатанд нээгээгүй болно.

Зургадугаар сарын 2-ны өдрөөс эхэлсэн хөл хориог сулруулах хоёрдугаар шатны арга хэмжээнд ресторан, кафе баар, ихэнх сургууль, урлаг, үзвэрийн газрууд болон спортын танхимууд үүдээ нээж, 100 километрийн хязгаарлалтыг цуцлахаар болов. Түүнээс гадна зургадугаар сарын 15-наас Франц улс Европын холбооны улсуудад хилээ нээхээр болсноо мэдэгдсэн.

Хэдий хөл хорио цуцлагдаж байгаа ч олон нийтийн газар болоод ажил сургууль дээр хоорондоо нэг метрийн зай барих, амны хаалт зүүх, зарим үйл ажиллагаанд 10-аас дээш хүн цуглахгүй байх зэрэг журам үргэлжлэх ба “Stop Covid” аппликэйшнийг утсандаа суулгаж, халдвартай хүнтэй ойр байсан тохиолдолд мэдээлэл авч байхыг зөвлөж байна.

Зарим асуудлын учрыг тайлвал

Маск болоод түргэвчилсэн оношлуур хүрэлцэхгүй байгаа нь Францад энэ халдвар дэгдсэн цагаас хойш яригдсан гол асуудлын нэг юм. Эдгээр нь дотооддоо үйлдвэрлэдэггүй бүтээгдэхүүн учраас



нийлүүлэгч орнуудаас хараат байж, тэдгээр улс дотоодын нөөцөө хангах зорилгоор нийлүүлэлтээ зогсооход Францын эмч, сувилагч нарт маск хүрэлцэхгүй болж эхэлсэн юм. Оношлуур дутмагаас болж массаар нь оношилгоо хийлгүй, өвчний хурц шинж тэмдэг илэрсэн тохиолдолд л эмчийн зааврын дагуу шинжилгээ өгөх боломжтой байсан.

Түүнчлэн “Stop Covid” аппликэйшнийг тойрсон маргаан намжихгүй байгаа бөгөөд иргэдийн олонх нь Францын төр эл аппликэйшнийг тусламжтайгаар хүмүүсийг мөрдөж, эрх чөлөөнд нь халдаж байна гэж үзэж буй.

Франц дахь монголчууд

Испани, Франц улсад нийт 5000 орчим монгол иргэн амьдардаг гэсэн мэдээ бий ч нарийвчилсан тоо гаргахад хүндрэлтэй.

Хил хаалттай энэ үед тусгай үүргийн нислэгээр нутаг буцах хүсэлтэй иргэд Монгол улсаас Франц улсад суугаа Элчин сайдын яаманд хүсэлтээ гаргаж болох ба холбогдох баримтуудыг бүрдүүлж өгсний дараа УОК-ын штаб нутаг буцах иргэдийг сонгож, сонгогдсон иргэд ХБНГУ-ын Франкфурт хотоос “МИАТ” ХК-ийн нислэгээр нутаг буцах боломжтой юм. ■



Швед улсад ажиллаж, амьдраад найман жил болж буй. Тус улсын нийслэл Стокгольм хотод амьдардаг.



Б.МИШЭЭЛ

Швед туршилт буюу сайн дурын дэглэм

Цар тахал ба шведүүд

Ковид-19 вирус анх Хятадад дэгдэхэд зөвхөн Швед гэлтгүй Барууны бүх улс маш тайван байсан. Улмаар олон тооны хүн халдвар авч, амь насаа алдаж байхад ч шведүүд амны хаалт зүүлгүй хойрго хандаж байлаа. Ер нь эндхийн эмийн сангуудад амны хаалт зардаггүй, иргэд нь ч хэрэглэж сураагүй. Харин амны хаалт зүүж, өөрийгөө хамгаалж байгаа азиудыг вирустэй, өвчтэй мэтээр хандах тохиолдол их байсан. Энэ тухай олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, сайтуудаар мэдээлж байсныг санаж байгаа байх. Ташрамд дурдахад шведүүд их үндсэрхэг үзэлтэй хүмүүс болох нь анзаарагдсан. Зөвхөн хятадууд биш, ер нь азиудыг гадуурхаж байв. Өсвөр насны хүүхдүүд хүртэл ази хүмүүсийг доромжилж, шоглосон видео бичлэг хийж интернэтэд тавьсан нь Шведэд байдаг монголчуудын эгдүүцэл, бухимдлыг маш их төрүүлсэн.

Европын бусад орны адилаар өнгөрсөн хэдэн сарын хугацаанд Шведэд халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж, олон хүн амиа алдаж, эмнэлгүүд ачааллаа дийлэхгүйд хүрсэн.

Ийм хүнд нөхцөл байдал үүссэний дараа л хүмүүс маск зүүж, гараа ариутгах нь чухал болохыг ойлгож эхэлсэн юм.

Коронавирус дэгдсэнээс хойш Шведийн Засгийн газар дэлхийн ихэнх орны адилаар хориг тавьж, хагуу арга хэмжээ аваагүй. Харин хэдэн сарын турш сайн дурын дэглэм баримталж ирсэн. Шведийн ерөнхий эпидемиологич, бодлого боловсруулагч, доктор Тэгнелл “Шинж тэмдэг илэрвэл гэртээ үлдэж, халдвар авсан тохиолдлын тоо тодорхой дээд цэгт хүрэх хүртэл энэхүү арга хэмжээг үргэлжлүүлнэ” гэж хэвлэлд ярьсан



байсныг энд эшлэе. Бусад улсаас ялгаатай нь Шведийн иргэд үүнд төдийлөн санаа зовж, эрс эсэргүүцээгүй бөгөөд санал асуулгын “Новус” компанийн судалгаагаар Ерөнхий сайд Стефан Лёфвений саналыг хүмүүсийн 80 хувь дэмжсэн аж. Тэрбээр өвчний тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд насанд хүрсэн иргэдийг хувийн хариуцлага хүлээхийг уриалсан юм.

Өнгөрсөнтэй харьцуулахад стокгольмчууд нийтийн тээврээр зорчихдоо бусдаас зай барихыг хичээдэг болсон. Стокгольм хотын нийтийн тээврийн компанийн мэдээлсэнээр метро болон автобусаар зорчдог хүмүүсийн тоо цар тахлын өмнөхөөс 50 хувиар буурчээ. Одоогоор аж ахуйн нэгж, цэцэрлэг, дунд сургууль нээлттэй, хэвийн ажиллаж байна. Стокгольмын гудамжны кафе болон ил задгай баарууд амралтын өдрүүдээр үйлчлүүлэгчийн хөл тасрахгүй байгаа гэхэд болно. ►

- Тавиас дээш тооны хүн олноороо цуглаж уулзаж болохгүй, ахлах сургууль, их дээд сургуулиуд зайны сургалт явуулах ёстой гэх мэт цөөн хэдэн заавал дагаж мөрдөх журам үйлчилж байна.

Эдийн засагт үзүүлж буй нөлөө



Шведэд вирусийн тохиолдол анх бүртгэгдэж, халдварын тархалт нэмэгдэж эхэлсний дараа Ази зоогийн газруудын орлого эрс буурч, ихэнх нь хаалгаа барихад хүрсэн. Үүнийг дагаад энд амьдардаг монголчууд ч ажилгүй болж эхэлсэн. Учир нь миний мэдэхээр Шведэд аж төрж байгаа монголчуудын дийлэнх нь сүши, хятад хоолны газарт ажилладаг. Би ч мөн адил сүши ресторанд ажиллаж байсан бөгөөд орлого буурч, халдварын тархалт дэгдсэнтэй холбоотойгоор манай эзэн бизнесээ хаасан юм.

Харин хэсэг хугацаанд хөл хорио тогтоосны дараа зоогийн газраа саяхнаас ариутгал, халдваргүйжүүлэлт хийгээд дахин нээсэн. Хүмүүс гадагш гарахаас болгоомжилж голдуу захиалгын хоол, хүнс авах болсон нь хүргэлт, захиалгын

үйлчилгээний бизнес нэмэгдэхэд нөлөөлж байна.

Өнөөдрийн байдлаар Ковид-19 вирусийн тархалт Шведэд төдийлөн буураагүй байгаа ч үйлчилгээний газрууд хэвийн ажиллаж байна.

Эдийн засгаа хямраахгүйн тулд төр, засгаас нь бизнесүүдийг дэмжиж, иргэдээ худалдан авалт хийхийг уриалж байгаа юм.

Зургадугаар сарын 12-ны өдрийн Шведийн “Аж үйлдвэрийн мэдээ”-нээс харахад тус улсын Төв банкны Мөнгөний бодлогын газар бусад улстай харьцуулахад хариу арга хэмжээ авах тал дээр сайн ажилласан боловч тодорхойгүй хүчин зүйлсээс шалтгаалж урт хугацаанд эдийн засгийн төлөв ямар байх нь хараахан тодорхойгүй байна гэжээ. Цар тахлын үед бусад улс хөл хорио тогтоож, иргэдээ тусгаарлах арга хэмжээ авсан нь эдийн засгийн салбаруудад ноцтой цохилт өгсөн болохыг онцолсон байв.

Харин Шведийн эдийн засагт цар тахал харьцангуй бага сөрөг нөлөө үзүүлсэн гэж болно. Халдварт өвчний үед Шведийн нийгмийн хөдөлгөөн бусад оронтой харьцуулахад илүү өндөр байсны дээр иргэдийн 44 хувь гэрээсээ ажилладаг нь нөлөөлсөн. Үүний зэрэгцээ Шведийн Засгийн газрын өрийн харьцаа бага байгаа нь тус улсад аж ахуйн нэгж, гэр бүлийг дэмжих хангалттай хөрөнгө гаргах боломж олгосон байна.

Гэсэн хэдий ч Швед экспортод чиглэсэн эдийн засагтай тул цар тахлын олон улсын худалдаанд үзүүлж буй сөрөг нөлөө нь тус улсын эдийн засагт хүндрэл үүсгэх боломжтой. Одоогийн байдлаар Шведэд өрхийн өр харьцангуй их байгаа бөгөөд энэ нь санхүүгийн салбарын гол эрсдэлд тооцогдож байна. Үүний зэрэгцээ гуравдугаар сарын 19-нд Швед улс хилээ хааснаас хойш цар тахал аялал жуулчлалын салбарт нь хамгийн хүнд цохилт өгч, ажилгүйдэл өдрөөс өдөрт нэмэгдэж, ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо эрс өссөн.

Швед улсад цар тахлын улмаас нас барсан хүний тоо Хойд Европын орнууд дундаа хамгийн их байгаа нь шүүмжлэлд өртөх шалтгаан болж байна. Тиймээс халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх стратегиа өөрчилж эхэлсэн. Гэсэн ч бусад улс орны нэгэн адил хатуу хяналт, торгууль, цагдаагийн арга хэмжээ авахаас илүү халдварт өртөмтгий, эмзэг бүлгийг хамгаалахад хөрөнгө оруулах бодлого барьж байгааг дурдах нь зүйтэй болов уу. ■



"Mongolian Economy" сэтгүүлийн Япон улс дахь сурвалжлагч. Токиогийн олон улсын их сургуульд олон улс судлаач мэргэжлээр суралцдаг.



Р.УНДАРБЯА

Хөл хорио тогтоосноор Токио орхигдсон хот болон хувирсан

“Энэ дайнд зөвхөн Засгийн газрын хүчээр ялах боломжгүй. Бидний хийж буй тэмцэл асар чухал бөгөөд амаргүй гэдгийг бүгд ухаарах ёстой. Японы ард иргэдэд хүндрэл учруулж байгаагаа бид ухаарч буй ч иргэн нэг бүрийг хамтран ажиллахыг хичээнгүйлэн хүсэж байна” хэмээн хэвлэлийнхний дайралт, шүүмжлэлд өртсөнийхөө дараа Японы Ерөнхий сайд Шинзо Абэ хоёрдугаар сарын сүүлчээр өгүүлсэн юм. Японы эрх баригчид, иргэд цар тахалтай бүх талаар тэмцэж буй бөгөөд хүнд байдлаас гарах урт зам тэднийг хүлээж байна.

Японыг нөмөрсөн цар тахлын дэгдэлтийг хоёр үед хувааж болно. Эхнийх нь нэгдүгээр сараас гуравдугаар сард, хоёр дахь нь гуравдугаар сараас өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Япон улс цар тахлын эсрэг хангалттай хариу арга хэмжээ авч чадахгүй байна хэмээн эрс шүүмжлүүлэх болсон нь “Diamond princess” усан онгоцны хэрэг явдалтай холбоотой. Эл дуулиант хэргийн дараа буюу хоёрдугаар сард Монгол Улс тус улс руу хийх нислэгийн тоог бууруулсан юм.

Тухайн үед би Монголд байсан бөгөөд бүх нислэгийг цуцлахаас өмнөх сүүлчийн нислэгээр Япон руу явах тийштэй байв. Найз, гэр бүлийнхэн маань Япон явахгүй байхыг зөвлөсөн ч би ниссэн. Эх орондоо нэг сар амрах хугацаандаа би монголчуудын дундах хэт санаа зовних явдлыг ажигласан бөгөөд “Монголд агаарын бохирдол дэндүү аюултай түвшинд хүрчихээд байхад маск зүүдэггүй мөртлөө жирийн ханиад гарахад маск зүүгээд байх юм” хэмээн шүүмжлэлтэй хандаж байлаа. Намайг зөвтгөх мэт хөгжингүй улс орнууд болон Барууны хэвлэл мэдээллээр цар тахлыг хуурамч мэдээлэл хэмээн дүгнэж байв. “Ковидиотууд болон хуурамч мэдээлэл” хэмээх



нийтлэлдээ би нийгэмд үзүүлэх коронавирусын нөлөөний талаар ч дурдсан нь бий.

Японд ирээд хүмүүс маск огт өмсөхгүй байгааг, мөн намайг явах үед ямар байсан тэр хэвээрээ нийгэм, эдийн засгийн амьдрал хэвийн өрнөж байгааг хараад ихэд гайхсан. Хоёрдугаар сарын сүүлчээр нэг ч япон хүн цар тахлыг огт тоомсорлохгүй байгаа мэт санагдав. Засгийн газраас хөл хорио тогтоох хүртэл би жуулчдын байнга очдог газар болон түүхэн дурсгалтай газруудаар бараг өдөр бүр аялаж байлаа. Хүмүүсийн хөл хөдөлгөөн багассан дээр олон газраар зочилж үзье гэж бодсон нь энэ. Япон улс ч гадаадын жуулчдыг улсдаа ирэхийг уриалж, хүн цөөнтэй үед хүссэн газраараа аял хэмээн урьж байлаа. Гуравдугаар сард Шинжүкү, Шибүя, Роппонги, Харажүкү Европын жуулчдаар дүүрэв. Чухам ингэж л Японд коронавирусын эхний давалгаа нүүрлэсэн юм. ▶

► “Токио-2020” олимпын наадмыг хойшлуулсны дараагаар байдал эрс өөрчлөгдөв. Ард иргэдийнхээ эрүүл мэндийг бодолгүй олимпын наадмыг эн тэргүүнд тавьж байна хэмээн дотоодын болон гадаадын хэвлэл мэдээллээр Японы төр засгийг шүүмжилж, анагаахын салбарын ажилтнууд харин Ковид-19-ийн хангалттай олон шинжилгээ хийхгүй байна хэмээн мэдэгдэж байв. Бусад улс орон хилээ

хааж эхэлсний улмаас Япон улс эдийн засгийн хувьд ихээхэн алдагдал хүлээж байгааг сануулья.

Хөл хорио тогтоосноор алдарт Шибүяа гарцаар гарах хүн үгүй болж, Токио орхигдсон хот болон хувирав. Токио, Киото, Саппоро зэрэг эрч хүчээр дүүрэн завгүй хотууд Засгийн газраас зарласан хөл хорионы үеэр дэлхийн сүйрлийн дараах хамхуул хийссэн хот мэт болсон. ■

Япон дахь монголчууд

О.Оюунхүү: Япон дахь монголчуудын хамгийн том асуудал бол мэдээллийн хомсдол

О.Оюунхүү Global Trust Network (GTN) байгууллагад карьер хариуцсан зөвлөхөөр ажилладаг. Японд төвтэй GTN анх түрээсийн батлан даалтын үйлчилгээ үзүүлдэг компаниас хүний



нөөц, амьжиргааны дэмжлэг, гадаадын иргэдэд зориулсан тусгай хөтөлбөр зэрэг зургаан салбарт ажилладаг болтлоо өргөжөөд байна. Мөн Япон, БНСУ, Монгол, Вьетнам улсад үйл ажиллагаа явуулж буй. GTN компани Японд суралцах сонирхолтой монголчуудод, бүхий л талаар туслах зорилготой.

Тухайлбал, бичиг баримт бүрдүүлэх, Япон хэлний жилийн сургалт явуулах, нэг жилийн турш хүссэн ажилдаа ороход нь туслах гэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг юм.

-Коронавирусийн цар тахал гарснаас хойш танай компани онлайн болон биечилсэн уулзалтаар хэдэн монгол хүнд үйлчилгээ үзүүлээд байна вэ?

-Одоогоор 100 орчим монголчууд манай хөтөлбөрт хамрагдаж буй. Тэдний ихэнхтэй нь би холбоотой ажилладаг юм. Коронавирусээ шалтгаалж компаниуд гаднын бус япон хүмүүсээ ажилд авахыг

илүүд үзэх болсон учраас ихэнх монголчууд цагийн ажлаа алдах болсон. Тиймээс тэд хоол, түрээсийн мөнгөний дутагдалд орж эхэлсэн.

Гаднын хүмүүсийг долоо хоногт 28 цаг ажиллахыг зөвшөөрдөг байсан бол одоо таван цаг болгож бууруулсан. Цагийн ажлын хөлс нь цагийн 1000 иен орчим байдаг гэж үзэхэд долоо хоногт ердөө 5000 иенээр амьдрах бараг боломжгүй. Ийм үед бид тэдэнд ажил олоход нь тусалж байна. Японд ирсэн монголчуудын хувьд хамгийн хүндрэлтэй зүйл нь хэлний мэдлэг. Зарим нь англи хэл ч мэдэхгүй ирдэг. Тиймээс мэдээлэл олж авахад их хэцүү. Эдгээр хүмүүст зориулж би монгол хэлээр подкаст явуулж эхэлсэн. Коронавирусийн тархалттай холбоотой шинэ мэдээлэл багтаасан дөрвөн подкастыг долоо хоногт хийдэг.

Мөн 100 мянган иен авах хүсэлтийн тухайд анкетийг хэрхэн бөглөх тухай нэгбүрчилсэн зааварчилгаа бүхий бичлэг хийлээ. Энэ талаар лавласан хүн бүрт бид энэхүү видеог явуулж байгаа.

-Бусад улсын иргэдтэй харьцуулахад Япон дахь монголчуудад цар тахал хэрхэн нөлөөлж байна вэ?

-Монголчууд ер нь их сэргэлэн хүмүүс шүү дээ. Японд амьдардаг монголчуудын хувьд хамгийн хэцүү зүйл бол шаардлагатай мэдээллээ олж авах юм. Жишээлбэл, визний хугацаа нь дууссан хүмүүс байна. Монгол, Японы хооронд онгоц нисэхгүй байгаа учраас тэдгээр хүмүүс нутаг буцаж чадахгүй болсон. Виз нь дууссан л бол цагаар ажиллах боломжгүй. Ийм нөхцөлд хүмүүс ямар ч мэдээлэлгүй эсвэл юу хийхээ мэдэхгүй болдог. Одоогоор Японы Засгийн газар

► коронавирусийн улмаас виз нь дууссан хүмүүсийн визийн хугацааг зургаан сараар сунгаж байгаа. Энэ мэдээллийг японоор эсвэл төрөлх хэлээрээ авч чадахгүй хүмүүс маш хүнд нөхцөлд орж байна.

Нэмж хэлэхэд Японд аялаж байгаад харьж чадахгүй болсон хүмүүс бий. Тэд Японд ирэх гэж ихэнх мөнгөө дуусгасан мөн очих газаргүй болсон. Саяхан Японд гудамжинд унтаж байгаа монгол залуугийн тухай мэдээлэл тарсан. Энэ бүхэн мэдээлэл дутмагаас л болж байгаа юм.

-Мэдээлэлгүй, эсвэл хүнд байдалд орсон ийм хүмүүст GTN хэрхэн тусалж байна вэ?

-Бид хаана очих, ямар бичиг баримт бүрдүүлэх, хэр хугацаанд хүлээх талаарх тодорхой мэдээлэл өгдөг. Мөн вэбсайтаар мэдээлэл оруулж байгаа. Коронавирусийн талаарх мэдээллийг бид англи, монгол, вьетнам, балба, португал гэсэн таван хэлээр бэлтгэдэг. Манай нийгмийн сүлжээний бүх платформуос энэ мэдээллийг авч болно.

-Цагийн ажил хийдэг хүмүүстэй харьцуулахад та бол компанийн ажилтан, тиймээс ажлын байрны баталгаа, эдийн засаг, санхүүгийн боломж харьцангуй их. Тан шиг компанийн ажилтан монголчуудад цар тахал ямар нөлөө үзүүлж байна вэ?

-Японы виз нь ажлын, урт хугацааны, оюутны гэх мэт байдаг. Оюутны визтэй хүмүүс долоо хоногт 28 хүртэлх цаг ажиллах эрхтэй. Урт хугацааны визтэй хүмүүсийн ажлын байрны баталгаа компаниас нь шалтгаална. Ажлын визтэй хүмүүсийн ажилгүйдлийн тэтгэмж, эсвэл даатгалыг Засгийн газар цалингийн 70 хувьтай дүйцүүлэн төлдөг. Одоогоор би долоо хоногт гурван өдөр ажиллаж байна. Энэ гурван өдрийн цалинг компани, харин үлдсэн хоёр өдрийн цалинг Японы Засгийн газар төлж буй. Цалин ерөнхийдөө 30 хувиар буурсан.

Хэрэв компанийн ажилтан цомхотголын улмаас ажилгүй болсон бол Засгийн газрын тэтгэлэг тэднийг аль болох хүнд байдалд оролгүй амьдрахад нь чиглэдэг.

-Та Японд цар тахлын үеэр мөн өмнө нь ч монголчуудтай хамтран ажиллаж буй. Цар тахлын улмаас тантай ажиллаж буй монгол хүмүүсийн зан аашинд гэнэтийн өөрчлөлт орох гэх мэт зүйл ажиглагдсан уу?

-Нийгэм маш их өөрчлөгдсөн. Хүнтэй нүүр тулж уулздаг ажил маань хөл хорионоос шалтгаалаад онлайн болсон. Гэрээс ажиллахад тэдгээр хүмүүсийн хүсэлтийг биелүүлэхэд арай хэцүү болсон юм

шиг санагдаж байлаа. Тухайн үед хүн бүхэн ямар нэг хэмжээгээр стресстэй байх шиг санагдсан. Учир нь ажил олдохгүй гэх мэт шалтгаанаас болж харилцагчдын маань орлого ихээхэн буурсан.

-Та Токиогийн олон улсын их сургуулийг төгссөн, мөн “Peer Assistant” үйлчилгээг санаачлан эхлүүлсэн. Тиймээс та Японд суралцдаг монгол оюутнуудын амьдралыг сайн мэднэ. Таны олж харсанаар цар тахал монгол оюутнуудад хэрхэн нөлөөлж байна вэ?

- Цар тахлын үеэр хамгийн их хэлмэгдэж, эмзэг байдалд байгаа хүмүүс бол оюутнууд. Өмнө хэлсэнчлэн тэдний орлогын эх үүсвэр байхгүй болсон. Японд сурахаар ирсэн ихэнх монголчууд сурахын зэрэгцээ ажилладаг. Коронавирусээс шалтгаалж орлогогүй болсон учраас тэдгэртэй байх болсон. Хэрэв гэртэй байж, хэн нэгэнтэй уулзаж эсвэл харилцахгүй бол стресст орох эрсдэлтэй. Мөн мөнгөгүй болсон учраас гэр бүлээсээ мөнгө гуйх шаардлага үүссэн. Гэрээс нь мөнгө явуулах боломжгүй бол байдал бүр хүндэрнэ.

Харин гэрээсээ мөнгө авдаг оюутнуудад байдал тийм ч хэцүү биш. Хичээл онлайн болсноор нийгмийн харилцаа үүсгэх боломжгүй болж эхэлсэн. Магадгүй энэ л оюутнуудад тулгарч буй гол бэрхшээл болов уу.

Хоёрдугаарт, энэ жил төгсөх гэж байгаа эсвэл дөнгөж төгссөн бакалаврын зэрэгтэй оюутнуудын байдал тун амаргүй байгаа. Эдийн засаг царцсан учраас ихэнхэд нь ажил олдохгүй болсон. Учир нь гадаад ажилтан авч эрсдэлд орохоос компаниуд эмээж буй. Хэрэв компанийн бүх ажилтан коронавирусийн халдвар авбал яах вэ? Энэ нь компанийн үйл ажиллагааг доголдуулж, ашиг олох боломжгүй болгоно.

-Зургадугаар сарын байдлаар халдварын тоо өмнөх саруудтай харьцуулбал буурч, хөл хорионы дэглэмийг суллаж эхэллээ. Эдийн засаг ч эргэн сэргэх төлөвтэй байна. Үүнийг дагаад танай компаниар үйлчлүүлэгчдийн ажилд орох, амьдралаа сайжруулах боломж дээшлэх болов уу?

-Манай харилцагчдын нөхцөл байдал аажим боловч сайжирч байгаа. Бэлнээр 100 мянган иен олгосон нь дотоод, гадаад гэлтгүй бүх иргэнд их дэмжлэг болсон. Хөл хориог цуцалснаас хойш ихэнх хүн ажилд орж, цагийн ажлын тоо, эрэлт нэмэгдсэн.

Мэдээж бүх зүйл алга урвуулахын төдийд сайжрахгүй. Ямартай ч Засгийн газрын дэмжлэгтэйгээр япон, гадаад гэлтгүй бүтдүрагшлахын төлөө чадах бүхнээ л хийж байна даа. ■

Боловсролын хүртээмж

Алдагдсан үеийнхэн

Нэгэн жишээ. “Сант” сургуулийн зургадугаар ангийн сурагчид хөл хорионоос хойш онлайнаар хичээллэх болов. Багш нар нь өдөр бүр фэйсбүүк группт даалгавраа оруулж, хариуг нь тогтсон өдөртөө авах бол математик, монгол хэлний хичээлийн хариуг сурагчид өдөртөө багтаад хийж явуулах үүрэгтэй. Эхний нэг сард багш, сурагчид зөвхөн фэйсбүүкээр “хичээлээ явуулдаг” байсан бол төдөлгүй Google classroom, Skype, Youtube зэрэг

эх нийлж, багшийнх нь гэрт хүүхдүүдийнхээ сүүлийн хэдэн сард хийсэн даалгаврыг аваачиж өгч, шалгуулсан байна.

Нэгэн жишээ. Д.Сундуйжав “Kings Kids” сургуулийн наймдугаар ангид суралцдаг. Хэдий тэрбээр харааны бэрхшээлтэй боловч хөл хорионы үеэр теле хичээлээ жирийн хүүхдүүдтэй адил хэмжээнд үзэж, багш нараасаа магтаал сайшаал сонсож буй. Компьютер дээр 10 хуруугаар мэргэжлийн шивж сурсан түүнд теле хичээлийн даалгаврыг мэйлээр илгээдэг багш нар, тэрхүү хичээлийг монгол хэлээр аудио файл болгон хувиргадаг тусгай программ нь “хань” болж байна. Хчизэл бүрээ хичээнгүйлэн сонсож, даалгавраа компьютерт нямбайлан шивж илгээх нь түүнд хэдийнэ энгийн үйлдэл болжээ. Д.Сундуйжав бол харааны бэрхшээлтэй хүүхэд жирийн сургуульд сурч болдогийг үлгэрлэж буй хүү. Харамсалтай нь түүний суралцаж асан 116-р тусгай сургуулийн 109 сурагч цар тахлыг үеэр теле хичээлээ үзэх боломжгүй хүнд байдалд буй. Салбарын яам нь энэ асуудлыг шийдвэрлэнэ гэж хөл хорионы эхэнд амласан ч тодорхой шийдэл гаргалгүй зуны амралттай золгожээ.

Энэ бол цар тахлын үед Монголын боловсролын байгууллагад ажиглагдаж буй гурван өөр өнгө. Үүний цаана хөдөөгийн, хотын, хотын захын дүүргийн, хэт олон сурагчтай, гар утастай, компьютергүй гээд дунд сургуулийн багш, сурагч нарт тохиолдсон түмэн бэрхшээл, мянган зовлон бийг мартаж болохгүй.

Боловсрол, эрүүл мэнд, амьдралын стандартаар хэмжигддэг хүний хөгжлийн индекс 1990 оноос хойш анх удаа энэ жил буурч болзошгүйг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр саяхан анхааруулсан. “2007-09 оны санхүүгийн хямрал зэрэг олон хүнд үеийг хүн төрөлхтөн сүүлийн 30 жилд даван туулсан. Хямрал болгон хүний хөгжилд хүнд цохилт болсоор ирсэн ч индекс ерөнхийдөө өссөөр иржээ. Харин эрүүл мэнд, боловсрол, орлогод зэрэг цохилт өгч буй Ковид-19 энэ хандлагыг өөрчилж байна” хэмээн тус хөтөлбөрийн зохион байгуулагч А.Штайнер мэдэгджээ. ►



илүү шинэлэг, хүүхэд ашиглахад хялбар, олуулаа харилцаж хичээл хийх боломжтой платформууд нэмэгдэв. Тэр хэрээр хүүхдүүдийн сурах идэвх, хичээлээ ойлгох чадвар нь ихэсчээ. Эдгээр платформын ачаар ангиараа онлайн хичээлд оролцох төдийгүй тест, шалгалтаа хялбархан өгч байв.

Нэгэн жишээ. Э.Мишээл нийслэлийн нэгэн дунд сургуулийн тавдугаар ангид сурдаг. Цар тахлын улмаас сургууль нь хичээллэхгүй болсноор тэрбээр зөвхөн теле хичээлд л найдаж толгойгоо цэнэглэх болов. Гэвч анги удирдсан багш нь хичээл бүрийг тайлбарлаж өгөхгүй, даалгавраа хийсэн эсэхийг нь ч тэр бүр шалгахгүй. Сүүлдээ багш нь фэйсбүүк, утсаар холбогдох нь ч багасав. Учрыг лавлавал амралтанд явсан байжээ. Хичээлийн жилийн төгсгөлд ангийнх нь хэдэн идэвхтэй эцэг

► Дэлхий даяар сургуулиуд хаагдсанаар дөрвөн сурагчийн гурав нь хичээлдээ явахгүй байгаа тооцоо гарчээ. Гэвч хүний хөгжлийн индекс ядуу буурай болон хөгжиж буй орнуудад илүү буурах хандлагатай аж. Учир нь тэдгээр улс баян орнуудтай харьцуулбал нийгэм болон эдийн засагт үзүүлж буй цар тахлын сөрөг нөлөөнд дасан зохицох, тэсвэрлэх чадвар муу байгаа юм.

Тэглээ гээд дэлхийн хүүхдүүд хичээлээ хийхгүй байхад Дэмбэрэл миний хүү хичээлээ хийгээд яах вэ гэсэн хандлага байж болохгүй. Дээр дурдсан жишээнээс үзвэл улсын сургуулийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цар тахлын үед сурах эрхээ тэр бүр эдэлж чадахгүй, хохирч байна. Цар тахлыг бэрхшээл биш боломж гэж харах ёстой. Ерөнхий сайд У.Хүрэлсүх “вакцин гарахаас нааш хилээ нээхгүй, өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлахгүй” гэж мэдэгдсэнийг бодолцож үзвэл 2020-21 оны хичээлийн шинэ жилийг сурагчид гэртээ угтаж ч мэдэхээр нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй.

Ийм эрсдэл байгаа үед энэ зун Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамгийн завгүй ажиллах ёстой болов уу. Учир нь хүүхэд залуучуудын орон хэмээгддэг манай улс цар тахлын “завсарлагын” улмаас эдийн засгаа сөхрүүлчихгүй гэж хичээхийн зэрэгцээ ирээдүй хойч үеийнхээ сурах, боловсрох, мэдэх эрхийг нь хөл хориогоор далимдуулж хөсөрдүүлж хэрхэвч болохгүй. Өнөөдөр үзээгүй эсвэл дутуу үзсэн хичээл тухайн хүүхдийн ирээдүйгээс хэрхэн хумслахыг таахын аргагүй. Тэр тусмаа Монгол шиг хөгжиж буй орны хувьд цар тахлын үеэр боловсролын салбартаа онцгой анхаарах ёстой. “Технологийн үсрэнгүй хөгжлийн ачаар хүүхэд хаанаас ч суралцах боломжтой цаг үед бид амьдарч буй атал гэнэтийн нөхцөл байдал үүсэхээр хүүхдийн хөгжил дараагийн асуудал болон орхигдож байгаа нь харамсалтай” хэмээн “Q education group”-ийг үүсгэн байгуулагч Ц.Алтансор өгүүлсэн.

Тиймээс хувийн сургуулиудын бэлэн сайн жишээг, сүүлийн үеийн техник технологийн дэвшилтэй хослуулан ирэх хичээлийн жилийг “үлгэр жишээ” явуулахад Боловсролын яамныхан минь анхаарагтун. Цар тахлыг дотооддоо алдаагүй гэж дэлхийд цоллуулж байгаа бол боловсролын салбараа ч энэ хүнд үед эрс өөрчилж, шинэчилж чадсан гэж магтуулж яагаад болохгүй гэж. Гэхдээ ингэхийн тулд DVD тараагаад үр дүнд хүрэхгүйг

сануулья. Өнгөрсөн дөрөвдүгээр сард НҮБ-ын суурин зохицуулагч Т.Мишра БСШУЯ-ны сайд Ё.Баатарбилэгтэй уулзаж, цахим сургалтын бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, агуулга, арга зүй, үнэлгээг сайжруулах, систем, техник технологийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд талууд хамтран ажиллана гэдгээ илэрхийлсэн сайн мэдээ бий.

Улс орны ирээдүй болсон хүүхдүүдийнхээ боловсролыг цар тахлын улмаас хөсөр хаяхгүйн тулд хичээж буй олон сайн жишээ бий. Тухайлбал, манайхтай хөгжил, хүн амын тоогоор ойролцоо Армен улс цахим хичээлийн хүртээмжийг сайжруулахын тулд бага орлоготой гэр бүлд компьютер олгох, үүрэн холбооны компаниудтай тохиролцсоны үндсэн дээр үнэгүй интернэт ашиглуулах, багш нарт зориулсан цахим сургалтын талаарх онлайн сургалт явуулах, хичээлийн онлайн бааз үүсгэх зэрэг авууштай аргыг хэрэглэж байна. Канадын Онтарио мужийн 15 мянган багш Боловсролын яамнаасаа зохион байгуулсан 14 хоногийн сургалтад хамрагдсан байна.

Танхимд бус онлайн орчинд сурагчдад, нэн ялангуяа бага ангийнханд хичээл заахын тулд багш нар тэс өөр арга барилаар ажиллах зүй ёсны шаардлага тулгарч буй. Энэ зун Монголын багш нар амрах бус Канад багш нар шиг “толгойгоо сайн цэнэглээд” авмаарсан.

Багш, эцэг эхийн оролцоо, теле болон цахим хичээлийн чанар зэрэг цар тахлын үед боловсролын салбарт зайлшгүй анхаарах асуудлаас гадна орхигдуулж болохгүй нэг зүйл бол эмзэг, ядуу өрхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын суралцах боломжийг бүрдүүлэх явдал юм. Түүнчлэн БСШУЯ-наас гаргасан судалгаагаар 35956 хүүхэд алслагдмал газарт байгаа бөгөөд дотуур байранд амьдардаг сурагчид хөл хорионы үеэр гэртээ харьж, интернэтгүй орчинд байгаа учир теле хичээл үзэх боломжгүй байжээ.

Нийгэм дэх тэгш бус байдлыг бууруулах, ирээдүйн боловсролтой иргэдийг бэлтгэхийн тулд цар тахлын үед гэртээ интернэтгүй, компьютергүй, ухаалаг утасгүй, тэр бүү хэл зурагтгүй айл өрхийн хүүхдүүдэд теле болон онлайн хичээлийг хүргэх нь нэн чухал юм. ■

Монгол шиг
хөгжиж буй орны
хувьд цар тахлын
үеэр боловсролын
салбартаа онцгой
анхаарах ёстой

Санхүү

Хямралын үед санхүүгээ амжилттай удирдах гурван алхам

Ковид-19 цар тахал компаниудын хаалгаа барих хамгийн том шалтгаан болж буй ч нөгөө талаар тэсэж үлдэх шалгарал болж байна. Тэсэж үлдэхэд туслах нэг том “зэвсэг” бол тухайн компанийн “хүмүүжил” буюу санхүүгийн үзүүлэлт юм. Цар тахалд хамгийн их нэрвэгдэж байгаа жижиг, дунд бизнесүүд санхүүгээ амжилттай удирдаж, сорилтыг даван туулах удирдлагын талаар зөвлөх үйлчилгээний www.sanhuuch.mn-ийг үүсгэн байгуулагч, санхүү, бизнесийн зөвлөх Ч.Мөнхбадрах дараах зөвлөгөөг өгч байна.

Одоогийн нөхцөл байдал

Бүх бизнес донсолсон, амаргүй цаг үе байна. Вирус анх дэгдэж байсан үетэй харьцуулахад нөхцөл байдал намжиж, бизнесийн эргэлт алгуур боловч явж эхэллээ. Гэсэн хэдий ч цар тахал хэзээ оргил үедээ хүрч, хөл хориог хэзээ суллах, вакцин хэзээ гарах нь тодорхойгүй байгаа. Тиймээс бид 2020 оны үйл ажиллагааны төсөөллөө зайлшгүй шинэчлэх ёстой. Өөрөөр хэлбэл, он дуустал хагас жилийг л таамаглаж чадна гэсэн үг. Явцын дунд дахин шинэчлэгдэж, өөрчлөгдөх магадлал өндөр.

Нөхцөл байдал тодорхойгүй байгаа учраас нэг хэсэг бизнес эрхлэгчид ажлын байраа хумисан, нөгөө хэсэг нь ажилчдаа тогтоон барих, үйл ажиллагааныхаа мөчлөгийг хадгалж үлдэхийн тулд ямар нэг байдлаар зээл аваад, өглөг үүсгээд ч хамаагүй тэсээд байна. Гэсэн ч бүгдийнх нь хувьд авлага нэхэгдсэн, өглөгтэй байгаа тул мөнгөний ийм сөрөг урсгал үүссэн баланс дээр яаж цааш явах вэ гэдэгт дараах гурван алхмыг хэрэгжүүлээрэй гэж зөвлөө.

Алхам 1: Зардлуудаа эрэмбэл

- Бизнес зогссон ч, явж байсан ч түрээсийн зардал гэх мэт тогтмол гардаг урсгал зардал гэж бий. Нэгэнт бизнес явахгүй нь тодорхой болсон бол түрээсийн төлбөрөө төлж чадахгүй. Түрээслүүлэгч нь түрээслэгчээ



алдчихвал орлогогүй болохоос гадна шинэ түрээслэгч олох гэж цаг хугацаа алдана. Тиймээс нэгэнт үүссэн энэ асуудлыг талууд харилцан ойлголцоод хувьсах зардалд шилжүүлэх нь оновчтой. Өөрөөр хэлбэл, одоо хуримтлагдаад байгаа зардлуудыг бизнес урагшилсан нөхцөлд төлсөн нь дээр. ►

- ▶ Урсгал зардлаас хамгийн том нь болох ажиллах хүчний зардлаа ч компани бүр боломжийн хязгаартаа тааруулаад зохицуулахаас аргагүй. Яаж ч хичээгээд ажилчдынхаа цалинг өгч дийлэхгүй бол харилцан ярилцаж түр хугацаагаар бууруулах нь зүйтэй.
- Дээрхээс гадна ойрын 3-6 сарын зайлшгүй зардлуудаа тодорхойлох хэрэгтэй. Орлогуудаа орж ирэх ба ирэхгүй эсвэл хойшилбол яах вэ гэсэн хувилбараар төсөөллөө гаргаж, боломж бололцоондоо тааруулаад хамгийн боломжит хувилбарыг сонгоорой.
- Компанийн санхүү зөв явдаг бол тодорхой хэмжээнд өр төлбөрөө барагдуулах хэмжээний бэлэн мөнгөтэй биш ч мөнгөнд хөрвөх чадвартай хөрөнгөтэй байдаг. Нэг ёсондоо, эрсдэлийн сан, шаардлагатай үед ашиглах нөөц хөрөнгөтэй компаниуд хямралыг давж үлдэж чадна.
- Бараа, түүхий эд нийлүүлдэг компаниас авах ёстой авлага, мөн бараа аваад борлуулж, өглөг үүсгэдэг байсан харилцааг шууд таслах хэцүү ч одоо зээлээр борлуулалт хийх цаг биш гэдгийг хатуу санаарай. Хуучин арга барилаа үргэлжлүүлээд л байвал танай компанийн найдваргүй авлагын хэмжээ улам ихсэж, мөнгөний урсгалыг хаах учраас үр дүнгүй. Гэхдээ бизнес явж байх нь хамгийн гол зүйл тул найдвартай харилцагч, борлуулагчдаа зээлээр өгч болно. Ер нь ийм үед тухайн нөхцөл байдлаас шалтгаалаад case by case гэсэн зарчмаар шийдэхээс аргагүй.
- Зээлийн эргэн төлөлтийн хувьд үндсэн зээлээ хойшлуулаад, хүүгийн төлбөрөө төлж байх нь чухал. Банкууд цаанаа төлбөртэй санхүүжилт босгож, түүнээсээ зээл олгодог тул зээлийнхээ хүүг төлөөд явбал банк цаашаа эх үүсвэрийнхээ төлбөрийг төлөх мөнгөтэй болно. Бас банкиндаа хариуцлагатай, ёс зүйтэй бизнес эрхлэгч гэдгээ батлах боломж юм.

Алхам 2:

- Тоонуудаа цаг алдалгүй цаасан дээр буулгах хэрэгтэй. Манай компанийн боловсруулсан excel загвар, автоматжуулалтыг цахим хуудаснаас татаж аваад хэрэглэхэд нээлттэй. Санхүүгийн сахилга батгүй явж ирсэн

бизнес эрхлэгчид цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртөж байгаа тул цаашид санхүүгийн сахилга баттай байхаас аргагүй болж байна. Өмнө нь санхүүгийн болон хүний нөөцийн зөвлөхүүдийн зөвлөгөөг ойшоож үздэггүй байсан бол одоо хүссэн, хүсээгүй хэрэгжүүлэхээс аргагүй болсон.

- Excel загвараар 2020 оныг дуустал орлого ба зардлын төсөөлөл, худалдан авалтуудын мэдээллээ оруулахад өөдрөг, бодитой, гутранги гэсэн хувилбараар төсвөө төлөвлөх боломжтой. Мөн сар, сараар гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргаж, мөнгө дутагдсан тохиолдолд эргээд дата төлөвлөлтөө өөрчлөх зэргээр сонгосон хувилбар, гүйцэтгэл хоёрынхоо ялгааг харж, хяналтаа долоо хоногоор, гүйцэтгэлээ сараар гаргаж, шаардлагатай бол он дуустал хувилбар бүр дээрээ “төсвийн тодотгол” хийх боломжтой.
- Гамшгийн үеийн төлөвлөгөөтэй болох хэрэгтэй. Хэрэв вирусийн тархалтыг дотооддоо алдвал гамшгийн нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй тул ажлын байр, агуулах савны хамгаалалтаа сайжруулах, хөрөнгийн даатгал хийлгэх зэрэг бэлтгэл ажлын зардлыг тооцон санхүүгийн төлөвлөлтөд тусгах хэрэгтэй. Гамшгийн нөхцөл байдал үүсвэл авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь энгийн, хураангуй байх нь оновчтой ба тухайн нөхцөл байдалд хэн, ямар арга хэмжээг авах, ямар зохион байгуулалтад орох тухай тоочсон жагсаалт байхад хангалттай.

Алхам 3: Боломжийг ашиглахад бэлэн байх

- Хямрал зөвхөн сөргөөр нөлөөлдөггүй. Нийлүүлэлт нь буурсан зарим бүтээгдэхүүний эрэлт огцом өсөх магадлалтай байдаг.
- Хямралын үед хөрөнгийн үнэ унах байдал нийтлэг. Ирээдүйд чухал шаардлагатай хөрөнгө хямд зарагдвал авах чадвартай байхыг хичээгээрэй.
- Засгийн газрын дэмжлэг тусалцаанд хамрагдах боломжоо хадгал. Үүний тулд ажлын байр, ажилчдынхаа үндсэн цалинг хэвээр хадгалахыг хичээх нь чухал. ■

Эрсдэлийн сан,
шаардлагатай
үед ашиглах
нөөц хөрөнгөтэй
компаниуд хямралыг
давж үлдэж чадна

Хүний нөөц

Хямралын үед хүний нөөцөө хэрхэн удирдах вэ

Цар тахлаас улбаатай хямралын үед ажилтнуудынхаа сэтгэл санааг тайван байлгахад удирдлага ямар үлгэр жишээ үзүүлэх, хямралын эсрэг байнгын төлөвлөгөөг хэрхэн боловсруулах тухай Монголын хүний нөөцийн мэргэшсэн менежерүүдийн холбооны тэргүүн, мэргэшсэн зөвлөх Ц.Цэцэгмаа зөвлөж байна.

Хорио цээрийн дэглэм тогтоосноос хойш нөхцөл байдал улам даамжирч, дэлхийн эдийн засгийн хямрал ужиграх хандлагатай боллоо. Гэвч нөхцөл байдалд тохирсон бодлого баримталж, тулгамдсан үед авсан арга хэмжээнүүдээ зөв дүгнэж, үнэлж чадваас маневр хийх боломж ямагт байдаг.

Харин цомхотгол хийж, ажилчдаа амраах, хаалгаа барих зэрэг арга хэмжээ авсан бол цаашид яах вэ гэдэг асуулт гарч ирнэ. Жижиг, дунд компаниудтай ажилласан 20 гаруй жилийн туршлагаас харахад хүндрэлийг зөвхөн удирдлагын цөөн хүн биш бүх ажилтнаа татан оролцуулж хамтын хүчээр давдаг юм. Ажилчдын оролцоог

нэмэгдүүлснээр асуудлыг илүү өргөн өнцгөөр харах давуу тал бий болохоос гадна үр дүнтэй шийдлүүд гарч ирдэг.

Хэвийн нөхцөлд удирдлагууд ажилчдаа сонсох цаг, завгүй байдаг бол хямралын үед тэдний санал бодлыг сонсож, оролцоог нэмэгдүүлэх боломж гарч ирдэг. Энэ бол хямралын нэг давуу тал юм. Энэ үед компаниуд хямралаас гарах удирдлагын баг болон бодлоготой болох хэрэгтэй. Оролцоот менежментийг бий болгохдоо санхүүгийн мэргэжилтнүүд, голлох нэгжүүдийн удирдлага, ажилтнуудын төлөөллөөс гадна сэтгэл зүйчийг багтаасан цогц бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэх нь чухал. Багаа бүрдүүлсний дараа бизнесийн дархлаа болон хүний нөөцөө авч үлдэх зөв аргуудыг үе шаттай хэрэгжүүлэх хэрэгтэй. Хямралын нөхцөлд авбал зохистой арга замыг ярилцаж, хямрал дуусахад хэрэгжүүлэх сэргэлтийн төлөвлөгөөг ч мөн боловсруулах шаардлагатай.



Олон жилийн турш бий болгосон бүтээгдэхүүн, технологи, хүний нөөцийн чадавхаа хамтын хүчээр хамгаалж үлдэх ёстой гэдгээ удирдлагын баг байнга санаж, үйл ажиллагааныхаа гол чиглэл болгох ёстой.

Хямрал бус боломж

Дэлхийн жишиг компаниуд болзошгүй эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө, бодлоготой байдаг. АНУ-ын Хүний нөөцийн менежментийн холбооноос явуулсан судалгаагаар нийт компаниудын 38 хувь нь үүсээд буй нөхцөл байдалд бэлэн биш байсан гэж хариулжээ. Харин үлдсэн хэсэг нь хямралын эсрэг менежментийн бодлоготой байв. Эндээс дүгнэхэд бид аливаа эрсдэлд ямагт бэлэн байх ёстой. Цар тахал үүнийг бидэнд дахин санууллаа.

Ачаалалхтэй үед хүний нөөцийн мэргэжилтнүүд эерэг харилцаа бий болгоход анхаарлаа хандуулахгүй байх нь элбэг. Наад зах нь их ажил амжуулж байгаа ажилтнаа үгээр урамшуулалгүй гомдоодог. Тэр тусмаа хямралын үед болж бүтэхгүйд нь анхаарлаа хандуулж, аль болох цомхотголд оруулах гэж хичээх бус ойлголцохыг хичээх хэрэгтэй. Иймд ойлголцолд хүрч эерэг харилцаа бий болгох нь чухал. Нөгөө талаас ажилтнуудын хувьд эдийн засгийн хөшүүрэг багасч байгаа тул компаниа гэсэн сэтгэлтэй ажилтнууд бий болгож чадсан уу гэдгийг дүгнэх цаг ирээд байна. Иймд өнгөрсөн хугацаанд ажилчдаа татаж чадаагүй, сэтгэл зүйд нь анхаарал хандуулалгүй ирсэн бол алдаагаа засах боломж бий болсныг ашиглах хэрэгтэй.

Удирдлагууд голдуу төлөвлөгөө баталж, үүрэг даалгавар өгдөг хандлага нь шаг доошлох тусам ►

Хямралын үед ажилтнуудаа идэвхжүүлж, завгүй байлгахад анхаарах хэрэгтэй

► ачаалал нэмэгдэхэд хүргэдэг. Харин хямралын үед бүх хүний оролцоо тэгш болдог онцлогтой. Тухайлбал, компаниуд борлуулалтын хэмжээгээ хадгалж үлдэхийн тулд зөвхөн борлуулалтын алба бус удирдлага, бусад ажилтны оролцоог нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлдэг. Ингэснээр бүгд нэг шугам дээр ирж, эрх мэдэл, албан тушаалын шат дараалал бүдгэрдэг. Учир нь борлуулалтаас нийт орлого, цаашлаад цалин хөлс шууд хамааралтай байдаг. Цар тахал гарснаар Хятадын олон компанийн удирдлага, ажилтны харилцааг сайжруулахад “Wechat” аппликэйшнийг идэвхтэй ашиглаж эхэлжээ. Тухайлбал, тус улсын эмэгтэй дотуур хувцасны томоохон компани болох “Cosmo Lady” ажилчдаа бүтээгдэхүүнээ “Wechat”-аар сурталчлахыг үүрэг болгосон байна. Ингэхдээ захирлууд, удирдах зөвлөлийн гишүүд болон топ менежерүүд ажилчидтайгаа адил даалгавар биелүүлэх үүрэг авч, бүтээмжээрээ үнэлүүлжээ.

Өөр нэг онцлогуудтай үзэгдэл бол Хятадын үзвэр, үйлчилгээний салбарынхан ажилгүй болж байхад “Alibaba” зэрэг технологийн компаниудын эрэлт нэмэгдэж, нэмэлт орон тоон дээрээ бусад компанийн ажлаа алдсан хүмүүсийг түр ажиллахыг урьсан байна. Зөвхөн хямрал гэлтгүй ердийн үед ч бие биенийхээ дутууг нөхөж ажиллах нь хамтын ажиллагааны нэгэн хэлбэр байх ёстой. Тухайлбал, аливаа компани тодорхой шалтгааны улмаас ажилчнаа халахад өөр нэг компани яг тэр мэргэжлийн хүнийг хайж байгаа бол холбож өгдөг байх хэрэгтэй. Ийм төрлийн хамтын ажиллагаа манай компаниудад дутагддаг. Мөн онлайн борлуулалтыг гол төлөв хувь хүмүүс хийж байгаа нь ажиглагддаг. Яагаад компаниуд үүнийг хийж болохгүй гэж? Ажилтнууд нь бүтээгдэхүүнээ онлайнаар борлуулснаар урамшуулал авах боломж бүрдэхээс гадна дотоод идэвхжил явагдах давуу талтай.

Хэмнэлт - стресс менежмент

Орлого буурч буй үед зардлуудаа ухаалгаар танах хэрэгтэй. Үүнд, шинэ ажилтан авахгүй байх, хүний нөөцийн үр ашигтай хөтөлбөр хэрэгжүүлэх, үндсэн цалингийн хэмжээг хадгалж зарим урамшууллыг танах зэрэг багтана. Гэхдээ ямар нэг арга хэмжээ авахаас урьтаж нөхцөл байдлаа сайтар үнэлж, дүгнэх хэрэгтэй. Зардлаа танана гэхээр хүнтэй холбоотой зардлуудаа хасах хандлага түгээмэл. Ажилчдаа өнөөгийн түвшинд хүргэхийн тулд байгууллагууд олон жил зарцуулсан байдаг учир хүний нөөцийн

дархлаагаа ухаалгаар хадгалж үлдэх ёстой.

Дурдахгүй өнгөрч болохгүй өөр нэг асуудал бол ажилчдын стресс. Хямралын үед стресс менежментийг зөв явуулахын тулд хамгийн түрүүнд дотоод нөөц бололцоогоо ашиглах боломж байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй. Тухайлбал, танай байгууллагад сэтгэл зүйч эсвэл хүний нөөцийн мэргэжилтэн байгаа бол сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадварыг нь ашигла. Мөн удирдлага тайван байж үлгэрлэх нь ажилчдын сэтгэл зүйд эергээр нөлөөлнө. Үүнээс гадна мэдээллийн урсгалыг зөв удирдаж хов, цуурхал тараахгүй байх нь чухал. Өөрөөр хэлбэл, “ийм учраас цалин буугаагүй гэнэ” гэх мэт яриаг тараах бус үнэн зөв мэдээллийг шуурхай түгээх үүргийг нэг хүн эсвэл багт ногдуулах хэрэгтэй. Мөн хүнд нөхцөлд амьдардаг эсвэл өрийн дарамттай хүмүүст цалинг нь түрүүлж өгөх эсвэл эрсдэлээс нь хуваалцах зэрэг арга хэмжээ авснаар стрессийг бууруулах боломжтой. Хямралын үед ажилтнуудаа идэвхжүүлж завгүй байлгахад анхаарах хэрэгтэй.

Хямралын эсрэг төлөвлөгөө

Коронавирусийн тархалтаас үүдсэн хямралтай төстэй хямралууд цаашид бий болох магадлалтайг эрдэмтэд сануулж буй. Иймд компаниуд хямралын үеийн байнгын төлөвлөгөөтэй байх ёстой. Гэнэтийн нөхцөл байдал үүсэхэд хурдан хугацаанд дасан зохицох төлөвлөгөө шаардлагатай. Өөрөөр хэлбэл, удирдлага “реактив” буюу аливаа үйл явдалд гал унтраах маягийн хариу үйлдэл үзүүлдэг бус “проактив” буюу урьдчилан харж төлөвлөдөг, идэвхтэй бодлоготой байх ёстой.

Олон улсын байгууллагууд энэ нөхцөлд ажилтнуудаа зайнаас буюу дижитал орчинд ажиллах арга барилд сургахыг санал нэгтэй зөвлөж буй. Хоёрдугаарт, бий болгосон хүний нөөцийн чадавхаа хадгалж үлдэх. Гуравдугаарт, хямрал өндөрлөж хэвийн нөхцөлд шилжихэд ажиллах төлөвлөгөө гаргах. Зайнаас ажиллах, уян хатан цагийн хуваарийг манай томоохон компаниуд харьцангуй амжилттай хэрэгжүүлж байгаа бол жижиг бизнесүүдийн хувьд дэд бүтэц нь хөгждөггүй, соёл төлөвшөөгүй зэрэг олон сорилттой тулгарч буй.

XXI зууны гол чиг хандлага дижиталчлалд чиглэж байна. Иймд алдаа, туршлагаа өөрсдийн цомхон хүрээлэлд бус олон нийт нээлттэй солилцдог платформтой болох хэрэгтэй. Нэгдсэн орчин бүрдсэнээр бусдын алдааг давтаж, цаг алдалгүй үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ. ■



Ж.ЭРХЭМТӨГС
СУИС-ийн Соёлын сургуулийн Соёлын үйлдвэрлэлийн
тэнхимийн эрхлэгч, Бүтээлч үйлдвэрлэл инновацын төвийн
захирал, доктор(Ph), дэд профессор

Бүтээлч үйлдвэрлэл – бизнесийн шинэ боломж

Бүтээлч үйлдвэрлэлийн салбар нь дэлхий дахинд хамгийн хурдацтай өсөж буй эдийн засгийн салбаруудын нэг юм. Энэ салбар дэлхийн эдийн засгийн 6.1 хувийг бүрдүүлж, жилд дунджаар 2.3 их наяд ам.долларын орлого олж, 30 сая ажлын байр бий болгодог. Бүтээлч үйлдвэрлэлийн салбар нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, тэгш бус байдлыг бууруулах, “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөрийн зорилтуудыг биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Бүтээлч үйлдвэрлэлийг түүхэн талаас нь авч үзвэл 1930-аад оны үед радио, телевиз, кино зэрэг тухайн үеийн дэвшилтэт технологиор дамжуулан уран бүтээлийг нийтийн хүртээл болгож эхэлсэнтэй холбон үздэг. Энэхүү хөгжлийн шинэ үйл явцыг анх Германы эрдэмтэн Адорно Теодор, Макс Хоркхеймер (1947) нар “Соёлын үйлдвэрлэл” гэж тодорхойлж “Соёлыг үйлдвэрлэлтэй хослуулах үйл ажиллагаа” гэсэн үзэл баримтлалаар томъёолсон. Харин 1980 оноос шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжлөөс улбаалж, бизнесийн салбарынхан сонирхох болсноор соёлын үйлдвэрлэл нь эдийн засгийн салбар болон хөгжих эхлэл тавигдсан. Улмаар 1990-ээд оны сүүлчээр Англи улсад бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний бодлого боловсруулж хэрэгжүүлсэн нь бусад улс бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулах эхлэл болсон төдийгүй дэлхий дахин бүтээлч эдийн засгийг хөгжүүлэх асуудалд ихээхэн анхаарахад түлхэц болсон.

Ер нь XX зуунд улс орнуудын хөгжлийн чиг хандлага техник, технологийн дэвшилд тулгуурласан эдийн засгийн үр ашгийг чухалчилж байсан бол XXI зуунд нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд мэдлэг, оюуны үнэ цэн улам бүр нэмэгдэн, хөгжлийн тулгуур хүний хүчин зүйлд шилжих үйл явц эрчимтэй өрнөж байна. Улс орны өрсөлдөх чадвар хүний тоо, газар нутгийн хэмжээ, байгалийн

баялгаар бус харин мэдлэг оюунд түшиглэн нөөцөө хэрхэн үр өгөөжтэй ашиглаж байгаагаас ихээхэн хамаарч, үүнд инновац шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болжээ. Шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацын үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, нийгмийн дэвшил, эдийн засгийн хөгжилд мэдлэг, бүтээлч байдал болон соёлын гүйцэтгэх үүргийг чухалчлах хөгжлийн цоо шинэ хандлага бий болсон. Энэхүү хөгжлийн шинэ нөхцөлд дэлхийн улс орнууд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, олон улсад өрсөлдөхөд бүтээлч үйлдвэрлэл давуу талыг бий болгож байгаа тул мэдлэгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг хэмээн тусгайлан бодлогоор хөгжүүлж байна.

Манай улс 1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр төрөөс баримтлах социалист системийн бодлого, арга барилыг өөрчлөх нийгмийн шаардлага зүй ёсоор бий болсон. Иймээс улс орныг зах зээлийн эдийн засгийн харилцаа, улс төрийн ардчилсан тогтолцоонд шилжүүлэх, цаашдаа тогтвортой хөгжих үндэс суурийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого, эрх зүй, хөдөлмөрийн харилцаа, санхүүжилтийн орчныг шинэчлэхэд ихээхэн анхаарч ирсэн.

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд үндэсний инновацын тогтолцоог төлөвшүүлэх, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, инновац гэсэн ойлголтыг “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль” (2006)-д анх тусгаж, улмаар “Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх” үндэсний хөтөлбөр (2007) баталж, хэрэгжүүлсэн ба “Инновацын тухай хууль” (2012) батлагджээ. Харин бүтээлч үйлдвэрлэлийн талаар 2012 онд “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-д тусгасан ба “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” (2015)-д бүтээлч үйлдвэрлэлийг

► хөгжүүлэх талаар стратегийн зорилт дэвшүүлж, улмаар “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр (2015) баглан хэрэгжүүлж байна. Мөн “Турван тулгуурт хөгжлийн бодлого” (2018)-д бүтээлч аж үйлдвэрийг хөгжүүлж, соёлын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ гэж тусгажээ.


Төрөөс инновац, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилт дэвшүүлж, цөөнгүй бодлого, эрх зүйн баримт бичиг боловсруулж, үндэсний хөтөлбөрүүд хэрэгжүүлж ирсэн боловч үр дүн нь хангалттай бус байна. Бодлого боловсруулагчид, судлаачид болон бизнес эрхлэгчдийн бүтээлч үйлдвэрлэлийн талаарх мэдлэг хангалтгүй, туршлага бага хэвээр байгаа тул энэ талын ойлголтыг нийгэмд төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.

Бүтээлч үйлдвэрлэл бол мэдлэгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болохын хувьд үндэсний инновацын тогтолцооны бүрэлдэхүүний нэг салбар байдлаар авч үзэх нь оновчтой юм. Үндэсний инновацын тогтолцоог Инновацын тухай хуульд (2012) “... инновацын үйл ажиллагаанд оролцогч өмчийн бүх хэлбэрийн байгууллага, тэдгээрийн харилцааны хэм хэмжээний цогц” хэмээн тодорхойлжээ. Иймээс уг тогтолцоог удирдлага төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, нийгмийн олон талт үйл ажиллагааг хамарсан янз бүрийн түвшин дэх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн оролцоо, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагаа, харилцан нөлөөлөл бүхий механизмаас бүрдсэн цогц систем гэж ойлгож болох юм.

Манай улсад бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан “Төр-Соёл-Бизнес-Зах зээл”-ийн үр ашигтай уялдаа холбоог хангасан үндэсний инновацын тогтолцоонд суурилсан дөрвөн дэд систем, тогтолцооны механизмын үүрэг гүйцэтгэх хүрээ болон бүтцийн үндсэн элемент (байгууллага) зэргээс бүрдсэн дараах “Бүтээлч үйлдвэрлэлийн экосистем”-д тулгуурлан хөгжүүлэх боломжтой юм (Зураг 1).

Энэхүү бүтээлч үйлдвэрлэлийн экосистем нь: i) салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох; ii) нэмүү өртгийн сүлжээний зураглалыг үндэсний хэмжээнд боловсруулах; iii) түүнд оролцогч талуудын үүрэг оролцоо, тэдгээрийн хамтын ажиллагааны хэлбэрүүдийг тодорхой болгох; iv)

Зураг 1. Бүтээлч үйлдвэрлэлийн экосистем



Тайлбар: I –Судалгаа, хөгжүүлэлтийн хүрээ, II –Үйлдвэрлэлтийн хүрээ, III–Арилжааны хүрээ, IV –Түгээн дэлгэрүүлэлтийн хүрээ.

тэдгээрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тогтоох; v) салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн төрийн үүрэг, оролцоо болон дэмжлэгийг тодорхойлох зэргээр бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг системтэй, алсын хараатай хөгжүүлж, түүнийхээ үр шимийг хүртэхэд чиглэсэн судалгаанд суурилсан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх суурь нөхцөл болох юм.

Манай улс ЮНЕСКО-ийн 2005 оны “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” конвенцид 2007 онд нэгдэн орсон. Уг конвенцийн IFCD (The International Fund for Cultural Diversity) сангийн санхүүжилтээр Бүтээлч үйлдвэрлэл, инновацын төвөөс “Соёлын үйлдвэрлэлийн бодлого боловсруулах үндэсний чадавхыг бэхжүүлэх” төслийг 2019 оны дөрөвдүгээр сараас эхлэн хоёр жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр i) бүтээлч үйлдвэрлэлд оролцогч талууд болох бодлого боловсруулагчид, судлаачид, бизнес эрхлэгчид, бүтээн туурвигчид нэгдсэн ойлголттой болох; ii) бодлого боловсруулагчдыг чадавхжуулах; iii) бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний зураглал болон стратеги боловсруулагдах юм. Ингэснээр бүтээлч үйлдвэрлэлийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр өсөхийн сацуу олон улсад өрсөлдөх үндэсний брэнд хөгжүүлэх урьдач нөхцөл бүрдэх болно. ■

Дэлхийн шинэ эмх замбараагүй байдал

Хэрэв Америк олон улсын байгууллагуудаас гарвал
бусад улс байр суурийг нь эзлэх ёстой

Өдгөөгөөс 75 жилийн өмнө Сан Франциско хотод Нэгдсэн Үндэстний байгууллагыг (НҮБ) байгуулах тунхагт 50 улс гарын үсэг зурсан юм. Тэд Польш улсад зориулж хоосон мөр үлдээсэн агаад тус улс хэдэн сарын дараа үүсгэн байгуулагч 51 дэх улс болсон билээ. НҮБ зарим талаараа олны хүлээлтээс давсан. Дэлхийн I дайны дараа байгуулагдсан Үндэстнүүдийн лигээс ялгаатай нь НҮБ олон зүйлийг тэсэж үлдэв. Колончлолыг халснаар гишүүн орнуудын тоо 193-т хүрэв. Дэлхийн III дайн ч гарсангүй.



Doug Chayka

Гэсэн хэдий ч НҮБ болон харьяаллын бусад байгууллага, тухайлбал хямрал, эх захгүй байдлыг зогсоох үүрэгтэй Дэлхийн худалдааны байгууллага (WTO), Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ (NPT) үүргээ тэр бүр биелүүлж чадахгүй байна. НҮБ гол төвд нь буй эл систем дотоодын асуудалд идэгдэж, Хятадын сэргэлттэй дасан зохицох гэсэн олон

улсын хүчин чармайлтад зүдэрч буйгаас гадна хамгийн гол нь бүтээн босгогч, ивээн тэтгэгч нь болсон АНУ-д гадуурхагдаж, тэр бүү хэл үзэн ядагдаж эхлэв.

Дэлхийн дэг журамд аюул учрах нь улс бүрт, тэр дундаа Америкт хамаатай. Хэрэв АНУ эл байгууллагыг үл тоовол бусад улс, тэр дундаа Япон, Герман зэрэг дундаж гүрнүүд, Энэтхэг, Индонез зэрэг сэргэж буй улсууд санаачилгыг гартаа авах хэрэгтэй. Хэрэв тэд эргэлзвэл 1920 болон 1930-аад оных шиг хар дарсан байдлыг санагдуулам айхтар сүйрлийн үрийг тарих эрсдэлтэй.

НҮБ бол хүндсурталтай, уурхүргэм байгууллага. Салбар байгууллагууд нь өөрийгөө сурталдах, хоёр нүүр гаргахдаа гарамгай. Тухайлбал, Хүний эрхийн үндэсний комисс нь Израилийг байнга донгоддог бол Аюулгүйн зөвлөл нь 1945 оноос хойш хүч чадал нь ихээхэн хумигдсан Британи, Франц зэрэг улсад санал өгөх эрх өгсөн мөртлөө Япон, Энэтэг, Бразил, Герман эсвэл Африкийн аль нэг улсад байнгын гишүүнчлэл олгодоггүй. Тус байгууллага яагаад ч шинэчлэгдэхгүй мэт санагдана.

Гэсэн хэдий ч дэлхийн дэг журмыг аврахаас өөр аргагүй. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Даг Хаммаршельд нэгэнтээ хэлсэнчлэн “НҮБ бол хүн төрөлхтөнийг диваажинд аваачих бус харин тамаас аврахаар байгуулагдсан” юм. Тэд эл үүргээ хэрхэн биелүүлж байна вэ? Тус байгууллагын энхийг сахиулагчид Нью-Йорк хотын цагдаагийн албанаас арай их төсвөөр 125 сая иргэнийг хамгаалж байна.

Мөн амьд явах наад захын хэрэглээгээр 103 сая хүнийг хангаж буй. Хэдий Аюулгүйн зөвлөл алдаа дутагдал ихтэй ч үгүй болчихвол санах хүн олон.

Яагаад гэвэл улсуудыг тэр чигт нь орхихивол тэд дайсагнасан байдал руу гулсана. Тухайлбал, өнгөрсөн долоо хоногт Энэтхэг, Хятадын арми хилийн маргаантай цэгт цус асгаруулав. НҮБ, ►

► НАТО, NPT нь энх тайвныг баталгаажуулж чадахгүй боловч дайн гарахгүй байх, гарсан ч хязгаарлагдмал хүрээнд байлгахыг чармайдаг. Франц бусад холбоотон улсын хамтаар Сахелийн бүс нутагт мөргөлдөөнийг тогтоон барихыг хичээж байна.

Олон талт хамтын ажиллагаа үгүй бол хуучны бэрхшээлүүд улам гүнзгийрнэ. Есөн жилийн турш дайнд нэрвэгдсэн Сири улс хүртэл нэг л өдөр НҮБ-ын бүрэн эрхэт төлөөлөгчийн энхийн төлөвлөгөөнд багтаж магадгүй. Харин энэ зуур шинэ бэрхшээлүүд шийдэгдэлгүй үлдсэн хэвээр. Нэг жишээ бол цар тахал. Вирус нь эмчилгээ, вакцин зэрэг дэлхийн хэмжээний шийдэл шаардах төдийгүй улс орны дотоодын эмзэг байдлыг улам гүнзгийрүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлт, зохион байгуулалттай гэмт хэргийн хувьд ч мөн адил.

Эл системийг эмх замбараагүйн хүчнээс хамгаалах нь хэлэхэд амар боловч хийхэд хэцүү үйл хэрэг мөн. Нэг аюул бол Америк, Хятадын хоорондох антагонизм. Нөгөөх нь Америк олон улсын байгууллагуудад өнөөгийнх шиг хайхрамжгүй байдлаар хандах. Ялангуяа Ерөнхийлөгч Д.Трамп хэрэв хоёр дахиа сонгогдоод улам бүр муухай аашлах аюул бий. Тэрбээр аль хэдийнэ Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагыг эрс шүүмжилсэн төдийгүй энэ сард Германд байрлаж буй Америкийн цэргүүдийн гуравны нэгийг эгүүлэн татна гэж мэдэгдсэн. Энэ нь НАТО-гийн хүчийг сулруулж, Америк улс хүч чадлаа Европоос Африк руу тэлэх боломжийг нь хязгаарлана.

Аз болоход дэлхий дахин эргэж буцахын аргагүй байдалд хараахан ороогүй байна. Олон арван жилийн турш тус системийг байнга арчлах үйл хэрэгт дундаж гүрнүүд Америкийн ам, гарыг харсаар ирсэн. Харин өнөөдөр тэд өөрсдөө улам их ачаа үүрэх хэрэгтэй байна. Бусад улс элсэхэд нээлттэй олон талт хамтын ажиллагааны санаачилгыг Франц, Герман үүсгээд байна. Өөр нэг санал гарсан нь Япон, Герман, Австрали, Канад зэрэг дэлхийн ДНБ-ий гуравны нэгийг бүтээдэг есөн улс хамтарч “дэлхийн дэг журмыг аврах хороо” байгуулах юм.

Хэдий Америк дэлхийн том гүрэн боловч бусад улс Цагаан ордны тусламж эсвэл тусламжгүйгээр асуудлыг шийдвэрлэж чадна. Британид амьдардаг Оросын тагнуулч асан Сергей Скрипалийг химийн зэвсгээр хордуулсны дараа Барууны орнууд Кремльд хориг тавьсан нь Америкт хүртэл нөлөөлж байв.

Харин Quad бол Хятадын тэлэлтэд, нэн ялангуяа Өмнөд Хятадын тэнгист ноёрхож буй байдалд нь санаа зовнисон Энэтхэг, Австрали, Япон, Америкийн холбоо юм.

Заримдаа дэлхийн улсууд Америкгүйгээр хамтран ажиллах нь хамгийн сайн биш юм аа гэхэд илүү дээр сонголт болох нь бий. Худалдааны асар чухал Trans-Pacific Partnership гэрээнээс Трамп Америкийг гаргасны дараа бусад гишүүн улс үүнийг үл хайхран гэрээг байгуулсан. ДХБ-гаас хангалттай дэмжлэг авч чадахгүй байгаа улсууд бүс нутгийн болон хоёр талт гэрээг ихээр байгуулах болов. Тухайлбал, Япон-Европын холбоо болон Африк тивийн 28 улсын хоорондын гэрээг дурдаж болно.

Олон улсын дэг журмыг хамгаалах нь мөн чухал. 2000 онд НҮБ-ын төсвийн нэг хувийг төлдөг байсан бол эдүгээ 12 хувь болгож өсгөсөн Хятад улс эл хувь нэмрийнхээ адилаар нэр хүнд, байр сууриа нэмсээр байна. Тус улсын дипломатууд НҮБ-ын 15 тусгай агентлагийн дөрвийг тэргүүлж байгаа бол Америкийнх ганцхан хороог удирдаж буй. Хэрэв бусад улс идэвхтэй ажиллахгүй бол эл систем Хятадын үзэл бодлыг илүүтэй тусгаж, гаднын зөвлөмж, саналыг хүлээж авахдаа хойрго болж магадгүй.

Зарим хүмүүс дундаж гүрнүүдийн үүрэг бол тус системийг АНУ өөр ерөнхийлөгчтэй болох хүртэл гацаалгүй ажиллуулах гэж үздэг. Гэвч тэдгээр улсын үүрэг зөвхөн үүгээр хязгаарлагдах ёсгүй. Санал асуулгаас харахад ихэнх америкчууд улсаа дэлхийн тавцанд илүү чухал үүрэг гүйцэтгэдэг байхыг хүсдэг нь харагдаж байгаа ч ЗХУ нуран унаснаас хойш Америк шоуг ганцаараа удирдах болсон учир “хоёр төвт” байдал руу эргэн очих боломжгүй. Үүний улмаас олон улсад янз бүрийн зөрчил үүсэх, үүнийг Орос, Хятад өөрсдөдөө ашигтайгаар ашиглах явдал ажиглагдах болсон төдийгүй Америкийн дотоодод ч дургүйцэл төрүүлэх болов.

Ерөнхийлөгч Барак Обама цагтаа бусад улс орныг Америктай хамтарч дэлхийг аюулгүй, тайван болгохыг хүссэн. Тэд хариуд нь толгой сэгсэрсэн. Харин одоо тэд тэрхүү алдаагаа дахин давтах ёсгүй. ■

© 2020 The Economist Newspaper Limited. Бүх эрх хамгаалагдсан.

The Economist сэтгүүлээс олгосон лицензийн дагуу **Mongolian Economy** орчуулав. Нийтлэлийн эхийг англи хэлээр www.economist.com сайтаас уншина уу.

Түгшүүрт үе айсуй

Хагас зуун жилийн настай цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ үе мөчөөрөө салж унахдаа хүрэв

**Шашанк
Жоши** батлан
хамгаалахын
редактор,
The Economist

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ (NPT) байгуулагдсаны 50 жилийн ой, хязгааргүй хугацаагаар сунгасны 25 жилийн ой 2020 оны гуравдугаар сарын 5-нд тохионо. Ердөө 13 улс цөмийн зэвсэгтэй болсноос Өмнөд Африк, Беларусь, Казахстан, Украин гэсэн дөрвөн улс зэвсгээ хураалгасан явдлыг эл гэрээг дэмжигчид баярлан тэмдэглэнэ. Гэвч төрсөн өдрийн баяр удаан үргэлжлэхгүй. Дипломатууд дөрөвдүгээр сарын 29-өөс тавдугаар сарын 10-ы хооронд Нью-Йоркт цугларч, гэрээний таван жил тутмын тайлангийн хуралд (RevCon) оролцоно. Цөмийн зэвсэгтэй улсууд зэвсэггүй улсуудтай сөргөлдсөнөөс 2005, 2015 онд зөвшилцлийн мэдэгдэл гаргаж чадаагүй учир сүүлийн хэдэн хурлыг бүтэлгүйтсэн гэж үздэг. Харин 2020 оны хурал гамшиг болж магадгүй.

Учир нь цөмийн зэвсгийн дэг журам нуран унаж байна. Ираны цөмийн хөтөлбөрийг 2015 онд хязгаарласан олон улсын гэрээ улам хүчээ алдана. Америк 2018 оны тавдугаар сард эл гэрээнээс гарсан бол Иран жилийн дараа гэрээг түдгэлзүүлэв. Иран улам их уран олборлож, центрифугаг улам хурдан угсрах болсноор маш хурдан цөмийн бөмбөг бүтээх боломжтой болно. Америктай хийж буй хэлэлцээ удааширч, өөрсдөд нь ногдуулсан хоригийг зөөллөх хүмүүнлэгийн тусламж дутмаг байгаад цухалдсан Хойд Солонгос цөмийн түлш улам их үйлдвэрлэж, холын зайны пуужингийн туршилтаа сэргээж болзошгүй. НАТО-ийн холбоотнууд ч хөдөлгөөнд орох шинжтэй. “Зарим улс цөмийн цэнэгт хошуутай мөртлөө байхгүй гэдэг. Үүнийг би хүлээн зөвшөөрч чадахгүй” гэж Туркийн ерөнхийлөгч Режип Тайип Эрдоан есдүгээр сард гомдоллосон.

Гэвч Нью-Йорк дахь дипломатуудын хувьд цөмийн зэвсэгтэй дэггүй улсууд бус цөмийн зэвсэгтэй байхыг нь зөвшөөрсөн Америк, Британи, Хятад, Франц, Орос хэмээх ихэс

дээдсүүд асуудлын үндэс болж байна. Яагаад гэвэл эл гэрээг тохиролцоо гэж ойлгож болно. Цөмийн зэвсэггүй улсууд эл зэвсгээс үүрд татгалзана гэж тохиролцсон бол цөмийн зэвсэгтэй тавт харин цөмийн зэвсгээ устгах чиглэлд “сайн итгэл үнэмшлээр” тохиролцоно гэж гэрээний VI-р зүйлд заажээ. Цөмийн зэвсэгтэй улсууд гэрээнд дурдсанаас огт эсрэг зүгт явж буйд Ирланд, Мексик, Шинэ Зеланд зэрэг олон улс гоморхож байна.

Ялангуяа Америк, Оросын хувьд энэ нь үнэний хувьтай юм. Эл хоёр улс зэвсгээ улам төгөлдөржүүлж, шинэчлэхэд, тухайлбал Оросууд цөмийн хүчээр ажилладаг залуурт пуужин зэрэг сонирхолтой шинэ зэвсэгт асар их мөнгө цутгаж байна. Зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг хязгаарлах зорилготой гэрээнүүдийг хоёул үл тоож байна. Дундын тусгалтай цөмийн зэвсгийн гэрээнээс 2019 оны наймдугаар сард гарсны дараа Америк хэд хэдэн дундын тусгалтай, хурдтай шинэ төрлийн пуужин турших бол НАТО харин Оросын ижил төрлийн зэвсгээс хамгаалах шинэ арга замын талаар ярилцана. Холын зайн тусгалтай пуужингийн хэрэглээг зохицуулдаг Шинэ гараа гэрээг шинэчлэх 2021 оны хоёрдугаар сар дөхөх тусам дэлхийн улсууд улам түгших болно. Зэвсгийн багавтар хүч нь нэмэгдэж буй Хятадыг эл гэрээнд нэгдэхийг Америк улам эрчтэй шаардах бол бусад нь үүнийг эс үйлдэхийн увайгүй шалтаг гэж үзнэ.

Цөмийн эмх замбараагүй байдал, том гүрнүүдийн ихэрхүү зан яаралтай арга хэмжээ авах ёстойг сануулсаар. Энэ тал дээр ахиц гаргахын тулд зарим улс шинэ төлөвлөгөө гаргаж ирнэ. Сайн итгэл үнэмшилтэй гэдгээ харуулахын тулд Америк “Creating an environment for nuclear disarmament” санаачилгыг дэмжихийг уриална. Эл санаачилга нь Америк болон бусад улсыг цөмийн зэвсгээ хураахад хүргэхийн тулд дэлхийн аюулгүй ▶



Constellation

MASTER CHRONOMETER CERTIFIED

Behind the elegance of every Master Chronometer timepiece is the highest level of testing: 8 tests over 10 days, to ensure superior precision and anti-magnetic resistance.

Ω
OMEGA

OMEGA Boutique:
Шангри-Ла Худалдааны төвийн 1-р давхар - Олимпын гудамж

► байдлын орчинг хэрхэн өөрчлөх шаардлагатай талаар судлах зорилготой юм. Аюулгүй байдлын бодлогодоо цөмийн зэвсгийг чухалчилж үзэхгүй байхыг цөмийн зэвсэгтэй улсуудад уриалах зэрэг бага хэмжээний үйл ажиллагаанд анхаарал хандуулсан “Stepping Stones”-ийг Швед санал болгоно.



Гэхдээ хамгийн чухал санаачилга бол 2017 онд 122 улс зөвшөөрч, 70 улс гарын үсэг зурсан Цөмийн зэвсгийг хориглох гэрээ юм. Хүн төрөлхтөнд цөмийн дайны үзүүлэх аймшигт хор нөлөөг таниулдаг цөмийн зэвсэггүй бүлэг улсуудын Humanitarian Initiative санаачилгаас уг

гэрээ төрж гарсан билээ. Тэдгээр улс 2015 оны RevCon-ий тохиролцоо, хэлэлцээний үр дүнд сэтгэл хангалуун бус байсан учир эл асуудлыг НҮБ-ын Ерөнхий чуулганаар хэлэлцүүлэхээр шийдсэн юм.

Эл гэрээ 2020 он дуусахаас өмнө, 50 улс баталсны дараа хүчин төгөлдөр болох бөгөөд урам хугалсан

RevCon үүнтэй зэрэгцэн ажлаа улам сайжруулна. Цөмийн зэвсэгтэй Америк, Орос зэрэг улс гарын үсэг зураагүй гэрээний хууль зүйн болон дипломат үр дагаврыг үл тоомсорлоход бэлэн байгаа бол Франц зэрэг бусад улс олон улсын жишиг хуулиудад үзүүлэх нөлөөнд санаа зовж байна. Эл гэрээ нь NPT-ийн орыг эзлэх бус түшиг болох учиртай гэж санаачлагчид нь мэдэгдсэн ч ижил төрлийн хоёр гэрээ нь хууль ёсны байдлын төлөө хоорондоо өрсөлдөх болуузай гэж бусад нь санаа зовох болов.

Хамгийн чухал буюу сүүлчийн RevCon-ийг сүйтгэсэн асуудал бол цөмийн зэвсэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрөөгүй байгаа Израиль улстай холбоотой. Үй олноор хөнөөх зэвсгээс (WMD) дэлхийг салгах хүсэлтэй олон улсын хувьд “Ойрх дорнодыг WMD-гүй бүс” болгох нь хүслийнх нь дээд юм. Америкийн хувьд энэ нь Израиль улсын оршин тогтнох эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг

Арабын голдуу улсуудын далайсан зүсээ хувиргасан муна юм. Ерөнхийлөгч Доналд Трампын бат дэмжлэгтэй, Ираны цөмийн зэвсгийн тэлэлтэд анхаарлаа хандуулж буй Израиль улс байр сууриа тавихгүй. NPT-ийн төрсөн өдрийн бялуу шалан дээр шидэгдэж магадгүй л юм. ■



www.mongolianeconomy.mn

Вэб хуудас шинэчлэгдлээ;

- **The Economist** булан
- Mongolian Economy-онлайн захиалга
- Агуулга баяжсан

Telephone: **7011-5476**